

IV.

ca

: 2013 3

著者(英)	Yuki Konagaya, Ichinkhorloo Lkhagvasuren, Mary Rossabi, Morris Rossabi
journal or publication title	Senri Ethnological Reports
volume	121
page range	129-180
year	2014-09-10
URL	http://doi.org/10.15021/00000862

IV. Чойжингийн Хурц, геологи, уул уурхайн яамны сайд асан

[2013 оны 3 сарт ярилцсан]

1. Хүүхэд нас
2. Москвад өнгөрүүлсэн оюутан ахуй цаг
3. Засгийн газрын дэргэдэх “Геологийн хайгуул, шинжилгээний газар”-т
4. Уул, уурхайн салбар дахь Зөвлөлт–Монголын хамтын ажиллагаа
5. “Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр”
6. Монголчууд эрдэс баялагийг ашиглаж байсан түүхээс
7. Уул, уурхайн салбарт “улсын үйлдвэрийн газар”-ууд
8. Уул, уурхайн салбар дахь “хувийн хэвшил”, “Оюу толгой”-н асуудал

1. Хүүхэд нас

Конагая Ююки (КЮ): За, өнөөдөр Монгол улсын Геологи, уул уурхайн яамны сайд асан Ч. Хурц тантай уулзаж байгаадаа бид нар их баяртай байна. Монгол улсын геологи, уул, уурхайн салбарын хөгжлийн сэдвээр ярилцах цаг гаргаж өгсөн явдалд танд талархал илэрхийлэхийг хүсэж байна. Энэ яриагаа бид нар таны бага насны дурсамжаас эхлэх бодолтой байна. Та хаана, хэдэн онд төрсөн бэ? Та өөрийн аав, ээж, ах, эгч, дүү нарынхаа тухай бидэнд ярьж өгнө үү.

Чойжингийн Хурц (ЧХ): За, би өнөөдөр та бүхэнтэй уулзаж байгаадаа баяртай байна. Би Монгол улсын Геологи, уул, уурхайн салбарт олон жил ажилласан мэргэжлийн геологич хүний хувьд, энэ салбарын эрчимтэй хөгжилт, түүний хурдтай уналтын гэрч болохын хувьд та бүхний сонирхсон асуултанд хариулахад бэлэн байна. Тэгээд яриагаа миний бага насны дурсамжаас эхэлье!

Би 1939 оны 3 сарын 2-ны өдөр одоогийн Сүхбаатар аймгийн Халзан сумын нутагт төрсөн хүн. 1939 он бол Монгол улс, Япон улс хоёрын хооронд дайн эхэлсэн он юм шүү дээ. Энэ дайн манай түүхэнд “Халх голын дайн” гэсэн нэрээр орсон юм. Япон улсын эзэн хааны Квантуны

арми үлэмж их хүчийг манай дорнод хилийн цаад талд, Өвөрмонгол, Манжуурын нутагт олон жилийн турш нууцаар хуралдуулж байгаад энэ дайныг эхлүүлсэн юм билээ. Гэвч Квантуны арми ялагдаад, монгол нутгаас хөөгдөж гарсан юм. Монгол улс жил бүрийн 8-р сарын сүүлчээр “Халх голын дайны ялалтын баяр”-ыг тэмдэглэдэг юм. Энэ дайнд Монгол улс ялсан явдал нь манай шинэ үеийн түүхэнд маш чухал ач холбогдолтой үйл явдал болсныг манай түүхчид онцлон тэмдэглэдэг юм. Танай оронд бол энэ дайны түүхийг бараг ярьдаггүй юм шиг байгаа юм. Тийм биз? Үүнд учир шалтгаан байгаа байх аа. Юуны өмнө Япон улс энэ дайнд ялагдсан учраас ярих сонин сэдэв болж чадахгүй байх. Энэ чинь эхнээсээ л түрэмгий дайн байсан шүү дээ. Тийм учраас дайныг эхлүүлсэн шалтгааны талаар одоо ярих нь тийм ч зохимжтой биш байх. Би одоо дайны сэдвээр ярихгүй. Энэ дайны түүхийг манай түүхчид хангалттай судлаад, үнэлэлт дүгнэлтээ өгсөн учраас надад нэмж хасах зүйл байхгүй.

Харин энэ дайн эхлэхийн өмнөхөн болсон чухал үйл явдлуудын тухай би цөөн үг хэлэх гэсэн юм. Япон улстай дайн хийх нь тодорхой болоод байсан 1939 оны эхээр манай засгийн газар манай хойд их хөрш ЗХУ-ын засгийн газарт хандаж, мэргэжлийн геологчдийн багийг ирүүлэх хүсэлт тавьсан байдаг юм. Ингээд удалгүй Николай Андреевич Маринов гэдэг хүнээр ахлуулсан “геологийн хайгуул, судалгааны анги” иржээ. Манай засгийн газар энэ ангид Дорнод монголын нутгийн усны нөөцийг судлаж, тогтоох даалгавар өгсөн байна. Энэ бүс нутагт Япон улстай хийх дайны гол үйл явдлууд болно хэмээн манай засгийн газар тооцоолж байсан юм байж. Дорнод монголын нутаг бол усны нөөц багатай, өргөн их тал нутаг юм шүү дээ. Дайн хийх үед энэ бүс нутагт цэрэг их хэмжээгээр төвлөрөх нь мэдээжийн хэрэг. Тэгээд тэднийг ундны усаар хангах асуудал маш хурцаар тавигдаж байж. Энэ бүс нутгийн малчин ардууд уламжлалт аргаар гаргаж авсан “гар худаг”-ийн усаар хүн, малын ундны усны хэрэгцээг хангадаг байж. Харин ийм “гар худаг”-ийн усаар дайнд оролцох цэргүүдийн ундны усны хэрэгцээг хангаж чадахгүй нь ойлгомжтой. Н. А. Маринов гуайн удирдсан энэ анги өмнөө тавьсан зорилтыг амжилттай биелүүлсэн юм билээ. Энэ ангийн хийж гүйцэтгэсэн ажил бол монголын геологийн хайгуул, судалгааны ажлын цаашдын хөгжилд ихээхэн түлхэц өгсөн гэж би хэлэх гээд байгаа юм. Юуны өмнө энэ анги монголын геологийн хайгуул судалгааны ажлыг орчин үеийн судалгааны аргачлалд тулгуурлан шинжлэх ухааны үндэслэлтэйгээр явуулах ажлын эхлэлийг тавьсан хэмээн хэлж болно. Энэ ангийг удирдаж ирсэн Н. А. Маринов гуай бол өөрийн бүх амьдралыг Монголын геологи, хайгуулын судалгааны ажилд зориулсан хүн байв. Тэрээр 2000 онд насан эцэслэх хүртлээ монголын геологи, хайгуулын судалгааны сэдвээр олон сайхан ном бичиж

хэвлүүлсэн том эрдэмтэн-судлаач хүн байлаа. Н. А. Маринов гуай Монголд ирж ажилласан тэр жил буюу 1939 оны 10-р сарын 6-ны өдөр Монгол улсын засгийн газрын шийдвэр гарч Аж үйлдвэр, барилгын яамны дэргэд “Уурхай ба ашигт малтмалын трест” байгуулагдсан юм. Ингэж манайд геологийн хайгуул, уул, уурхайн асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгуулага байгуулагдсан юм. 1939 онд Монголын геологи, уул уурхайн салбарын цаашдын хөгжилд томоохон үүрэг гүйцэтгэсэн ийм чухал үйл явдлууд болж байжээ.

Миний аав бол малчин удамтай хүн байсан. Гэхдээ тэрээр өөрөө мал маллаж байсангүй. Миний аав одоогийн бидэнтэй адилаар сургуульд сурч байгаагүй боловч монгол бичгээрээ маш сайн уншиж, бичиж чаддаг хүн байсан юм. 1920-оод оны эхээр манай Дарьганга нутгаас анх дөчин хүн Ардын цэрэгт татагдаж явсан юм билээ. Түүний нэг нь миний аав байж. Тэрээр “би цэргийн алба хааж байх үедээ уншиж, бичиж, тоо бодож сурсан” гэж бидэнд ярьдаг байсан юм. 1925 онд тэрээр МАХН-д гишүүнээр элссэн байдаг юм. Тэр цагаас хойш л миний аав МАХН-аас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэхийн төлөө л зүтгэж, аймаг, сумынхаа бүхий л ажилд оролцож явжээ. 1927-1930 онд миний аав сумын засаг даргын албыг хашиж байж. Энэ аав бол миний өргөж авсан аав юм шүү дээ. Миний өөрийн төрсөн аав бол миний өргөж авсан аавын төрсөн ах нь байсан юм аа. Тэрээр төрсөн дүүдээ өөрийнхээ хүүг өргүүлсэн юм байж л дээ. Би чинь ийм аавын гар дээр өссөн хүн л дээ. Тэгээд айлын өргөмөл ганц хүү нь болж байгаа юм шүү дээ. Монгол айлын ганц хүүхэд ямар “эрх, ямба” эдлэж байдаг тадаар та нар сонссон байж магадгүй. Би тийм л байдлаар өссөн хүн. Миний аав, ээж хоёр намайг их эрхлүүлдэг байж. Би энэ аав, ээжийнхээ үгийг нь сонсож, тэднийхээ сургаалиар хүмүүжсэн хүн юм аа. Миний итгэл үнэмшил, хүмүүсийн тухай бодол болон энэ ертөнцийн тухай ойлголт тэдний нөлөөн дор буй болсон хэмээн хэлж болох байх. Миний аав намайг буруу хэрэг хийлээ гээд загнаж байгаагүй. “Аав намайг загнана!” гэж айж байсан тохиолдлыг би санадаггүй юм.

Гэхдээ, одоо бодоод байхад ааваасаа их сүрдэж байсан юм шиг байгаа юм. Би аавынхаа зааж, сургасан замаар явсан учраас “геологич” гэсэн ийм сайхан мэргэжил эзэмшсэн, бас төрийн өндөр алба хаших боломжтой болсон хэмээн бодож явдаг юм. Намайг ийм замаар явуулахын тулд мий аав их хүчин чармайлт гаргаж байсан байх л даа. Намайг төрийн өндөр алба хашиж байх үед ч миний аав хүрч ирээд “За, чи ийм ажлуудыг зөв хийж байна, харин ийм ажлуудыг буруу хийж байна шүү! Үүнийг яаралтай засаж, залруулах хэрэгтэй!” гээд надад хэлээд өгдөг байсан. Би ааваасаа ийм их тусламж, дэмжлэгийг авдаг байв. Одоо би

өөрөө аавынхаа тэр байранд ирчихээд байна. Манай ах, дүү төрөл, төрөгсөд миний үгийг сонсох гээд над дээр ирдэг болж. Тэгээд би одоо тэд нарт зөв, бурууг ялгаж, зааж өгдөг ганц хүн болчихоод байна. Манай ах, дүү, төрөл, төгсөд дотроос би л төрд нилээд өндөр албан тушаал хашиж явсан юм байна.

Ичинхорлоо Лхагвасүрэн (ИЛ): Та бага сургуульд хаана, хэзээ орсон юм бэ?

ЧХ: Би Сүхбаатар аймгийн 10 жилийн дунд сургуулийг төгссөн хүн юм шүү дээ. Тэнд бага сургуульд орсон. Намар 9 сарын 1-нд сургууль цуглахаар би сургуульдаа дандаа мориор ирдэг байлаа. Ер нь манай үеийнхэн бүгд л тийм байсан юм шүү дээ. Улаанбаатар хотод сүүлийн үед “сургуулийн автобус” буй болоод хүүхдүүд түүгээр сургуульдаа ирж, очдог болоод байна. “Сургуулийн автобус” буй болохоос өмнө нэг хэсэгхэн хугацаанд эцэг, эх нь өөсрдийн машинаар хүүхдүүдээ сургуульд нь хүргэж өгдөг байлаа шүү дээ. Зарим хүмүүс үүнийг “манайхан хэтэрхий тансаг байна!” гээд л шүүмжилж байлаа. Гэхдээ хөдөө орон нутагт бол байдал одоо ч өөр байна. Бидний үе шиг хүүхдүүд сургуульдаа мориор ирж, очдог газрууд олон байна. Би чинь 10 сарын 1-нээс дараа жилийн 4 сарын 1 хүртэл аймгийн төв дээр суудаг байв. Дунд сургуулийн улирлын амралт эхлэхээр би морио унаад, хөдөө байгаа гэртээ харьдаг байлаа. Би бага сургуульд орохоосоо өмнө, бараг 5 настай байх үедээ одоогийн бидний хэрэглэж байгаа “шинэ үсэг”-ээр уншиж, бичиж сурсан хүн юм шүү дээ.

Та нарт сонин байж магадгүй, энэ тухай би товчхон хэдэн үг хэлье. 1944-1945 оны мичин жил, манай нутагт айхтар сүрхий зуд болсон юм. Тэр жилийн зуд бол монгол орныг бараг бүхэлд нь хамарсан их зуд байсан юм шүү дээ. Монголчууд “мичин жил зуд болдог!!!” гэж ярьдаг нь бас ч оргүй хоосон яриа биш юм шүү. Нүүдэлч-малчин ардууд чинь энэ байгаль, дэлхийгээ байнга л ажиглан харж байдаг юм шүү дээ. Тэгээд хэзээ зуд болох, хэзээ ган болохыг нь урьдчилан мэддэг арга, туршлагатай болсон байдаг юм. Тэр жил манай нутагт цас их орсон тул мал бэлчих бэлчээргүй болсон байна. Ингээд нутгийн ардууд малаа аваад цас бага орсон нутаг руу “отор-нүүдэл” хийхээр болжээ. Отор-нүүдлийн тухай та нар мэдэх байх аа. Отор-нүүдлийг манай малчид хавраас бусад жилийн аль ч улиралд хийдэг юм. Тухайлбал зуны улиралд бороо орохгүй удаад малын бэлчээр муудвал малаа аваад бороо, хур элбэгтэй нутаг руу отор-нүүдэл хийнэ. Намар бол малаа таргалуулах зорилгоор өвс, ус сайтай нутаг руу отор-нүүдэл хийнэ. Ингэж отор-нүүдэл хийдэг уламжлал манайд ер нь маш эртнээс л бий болсон байх. Тэр жилийн зуднаар миний аав малаа аваад бас отор-нүүдэл хийхээр болж, би түүнтэй хамт явахаар боллоо. Би тэмээнд ачуулаад, олон давхар нэхий дээлээр хучуулаад явж

байснаа одоо тодхон санадаг юм. Аав бид нар Монгол–Хятадын хилд бараг тулж очоод, хилээс их ойрхон, цас багатай нутагт гэрээ барьсан юм. Одоо энэ нутаг “хилийн бүс”-д ороод хүн, мал нутаглаж болохгүй болсон байна билээ. Бидэнтэй хамт нутгийн өөр хүмүүс бас явсан л даа. Ингээд бид нар нийт отрын гэр 3-ыг бариад, түүндээ хуваагдаж ороод сууцгаасан юм. Тэр үед манай оронд “Бүх нийтийн бичиг, үсэг үл мэдэх явдлыг арилгах хөдөлгөөн” ид өрнөж байжээ. Улаанбаатар болон аймгийн төв зэрэг төв суурин газруудаас ирсэн багш нар хөдөөний айлуудаар явж бичиг, үсэг заадаг байж. Ингээд манай отор буусан газар бас нэг багш ирсэн юм билээ. Гэтэл түүгээр бичиг, үсэг заалгах хүн байсангүй. Отор хийж яваа хүмүүст бичиг, үсэг заалгах зав олдохгүй шүү дээ. Бүгд л өглөөнөөс аваад, орой болтол ажилтай байна. Нэг нь малаа хариулж байхад, нөгөө нь алга болсон малаа хайгаад өдөржин явдаг байх жишээтэй. Ингээд манай “отрын гэр”-т тэр багш бид хоёр л үлдэж байсан байх. Хийх ажилгүй хоёр нь л үлдэж байсан байх л даа. Тэр багш надад цагаан толгойн 35 үсгийг зааж, намайг уншиж, бичиж сургасан юм. Одоогийн бидний хэрэглэж байгаа Кирилл цагаан толгой чинь уг нь бол 33 үсэгтэй шүү дээ. Үүн дээр манай “монгол бичиг”-т байдаг “ө”, “ү” гэсэн хоёр үсгийг нэмээд 35 үсэгтэй болсон юм. Би ингэж цагаан толгойн үсэг сурч, уншиж, бичиж чаддаг болсон юм. Тэр үед би бас шатар, даалуу тоглож сурсан юм аа. Аав бидэнтэй хамт манай хамаатангийн нэг өвгөн ирсэн юм. Тэр өвгөн манай хонийг хариулдаг байв. Тэр өвгөн өөрөө шатар маш сайн тоглодог хүн байж. Ингээд тэр өвгөн орой болгон надтай шатар тоглодог байв. Эхлээд би шатар мэдэхгүй байлаа. Тэгээд тэр өвгөн шатар яаж тоглодогийг надад зааж өглөө. Удалгүй тэр “Алив, хүүхээ! Шатар аа аваад ир! Хоёулаа тоглох уу?” гэдэг болсон юм. Ингэж би шатарт дуртай болсон юм аа. Би одоо ч шатар тоглосоор л байна. Ер нь монголчууд шатар тоглох эртний их уламжлаттай ард түмэн юм шүү дээ. Одоо манай орон дэлхийн шатрын аврага шалгаруулах тэмцээнд байнга оролцож байна. Манайд шатрын олон улсын хэмжээний мастер нилээд хэд бий. Саяхан Дэлхийн шатрын холбооны ерөнхийлөгч К. Үлэмжийнов манай оронд ирээд буцлаа. Тэр хүн уг нь халимаг монгол хүн л дээ. Дэлхийн шатрын холбоо манай оронд “Шатрын ордон” барих төлөвлөгөөтэй юм байна. Манай оронд шатар тоглодог хүний тоо маш олон болохоор дэлхийн шатрын холбоо ийм шийдвэр гаргаад байгаа юм байж.

Тэр үед манай “отрын гэр”-т их олон хүн ирдэг байв. Голдуу л малаа хайж яваа хүмүүс ирж хонодог байлаа. Тэр жилийн зуднаар манай нутгийн бараг бүх мал аав бидний отор хийж байгаа нутагт ирж өвөлжсөн байх аа. Энэ нутагт цасан шуурганд уруудаад олон мал ирдэг байв. Ингэж цасан шуурга уруудаад энд ирсэн малаа эзэн нь хайгаад, хойноос нь

ирдэг байв. Ингэж малаа хайж ирсэн хүмүүсийн зарим нь манай отрын гэрт хонодог байв. Манай гэрт хонож байсан хүмүүсийн тоо зарим үед бараг 30 хүрч байсан байх шүү. Өвлийн улиралд 5-6 цагийн орчим нар жаргадаг шүү дээ. Тэгээд л удхагүй харанхуй болчихно. Малаа хайж ирсэн хүмүүст бид нар голдуу адууны мах чанаж өгдөг байв. Орой хоол идсэний дараа том хүмүүс голдуу л даалуу тоглодог байлаа. Эрт унтахгүйн тулд ингэж даалуу тоглож, цаг өнгөрөөдөг байсан юм. Өвлийн отор хийж байх үед эрт унтаж болохгүй. Өдөр билчээрт гараад буцаж ирсэн малаа байнга ажиглаж харах хэрэгтэй байдаг юм. Мал билчээрт гараад өвс сайн идэж чадсан байна уу, чадаагүй байна уу гэдгийг ажиглах хэрэгтэй байдаг юм. Хэрвээ мал өдөр билчээрт гараад өвс сайн идэж чадаагүй байвал дараа өдрийн малын билчээрийг хэрхэн зохион байгуулах вэ гэх зэрэг асуудал гарч ирдэг юм. Зарим хүн “мал маллах амархан” гэж боддог байж магадгүй. Тийм биш. Малчин хүний нэг өдрийн ажил өглөөний 4-5 цагийн үед эхлээд шөнийн 11-12 цаг хүртэл үргэлжилдэг юм шүү дээ. Ингэж даалуу тоглож байх үедээ аав болон бусад хүмүүс ээлжээр гэрээс гарч хотонд байгаа малаа ажиглаж хардаг байв. Бас цаг агаарын байдлыг ажиглана. Аавыг ингэж гэрээс гарах хооронд нь би түүний даалууг аваад түний оронд тоглодог байв. Ингэж би даалуу тоглож сурсан юм. Харин даалуу тоглох уламжлал монголд байхгүй л дээ. Хийх ажилгүй хүмүүс цагийг өнгөрөөхийн туд л даалуу тоглодог байсан байж магадгүй.

Намайг бага байхад миний аав надад бас үлгэр их ярьж өгдөг байв. Аавын ярьж өгсөн үлгэрүүдийг бараг бүгдийг нь би өөрөө цээжээрээ ярьж чаддаг байлаа. Аав үлгэр яриад өгвөл би түүнийг нь шууд л тогтоогоод авдаг байж. Монгол ардын үлгэр чинь урт, богино янз бүр л байдаг шүү дээ. Ер нь одоо бодоход би юмыг их амархан сурдаг хүүхэд байсан юм шиг байгаа юм. Аливаа шинэ юмыг маш хурдан сурдаг байж.

Сургуульд сурч байх үед би ангидаа хамгийн жижигхэн биетэй хүүхэд байлаа. Тэгээд багш намайг хамгийн урд эгнээний ширээнд суулгадаг байв. Манай ангид надаас их өндөр, том биетэй хүүхдүүд олон байсан юм. Бас насаар надаас ах хүүхэд ч цөөнгүй байсан даа. Би чинь ангидаа сурлага их сайтай, тоо их сайн боддог хүүхэд байлаа. Тэгээд тоогоо бодож чадахгүй зарим хүүхэд надаар бодуулдаг байв. Жижиг биетэй хүүхдийн “зовлон” гэж бас байсан юм аа. Манай ангийн “томчууд” намайг чирч аваачаад хажуудаа суулгаад “За, чи үүнийг бод! Хурдан бодоорой! Хурдан бодохгүй бол зодно шүү!” гэнэ шүү дээ. Эрэгтэй нь ч адилхан, эмэгтэй нь ч адилхан! Тэгээд л тэдний тоог нь бодож өгдөг байв. Миний бодож өгсөн тоог тэд нар бие биенээсээ хуулж бичээд багшид үзүүлчихдэг байлаа. Иймэрхүү байдлаар л сургуульд сурч байлаа даа. Сургуульд сурч байгаа хүүхдүүд гэртээ ирээд хичээлээ давтдаг шүү дээ.

Би чинь тийм юмыг огт хийж байсангүй. Сургуулийн амралт эхлэхээр би гэртээ морио унаад харьчихна. Гэртээ ирээд хичээл давтах боломж надад ерөөсөө байхгүй. Манай ээж хөл их муутай хүн байлаа. Тэгээд би түүнд туслаж гэрээ цэвэрлэнэ, ундны усаа худгаас зөөж авч ирнэ, түлэх түлээгээ хагалж бэлтгэнэ, хурга, ишигээ хариулна. Би энэ бүх ажлыг амжуулаад хийдэг байв. Сургууль дээр багшийн ярьж өгсөн зүйлүүд бол миний толгойд тэр чигээрээ байж л байна. Багш юу л ярина, түүнийг нь яг тогтоогоод авчихна шүү дээ. Ийм маягаар би арван жил дараалан онц сурлаа. Ингээд 17 настай дунд сургуулийн 10р ангиа төгсөж байлаа. Ингээд 1957 оны зун аавтайгаа хамт би анх удаа Улаанбаатар хотод ирж байлаа. Дээд сургуульд орох зорилготой юм шүү дээ.

2. Москвад өнгөрүүлсэн оюутан ахуй цаг

КЮ: Та геологич мэргэжлийг өөрөө сонгож авсан уу?

ЧХ: Тэгсэн. Гэхдээ энд бас олон учир шалтгаан бий. Би чинь анх “мөн адил” гэдэг Их сургуульд сурах хуваарь авсан хүн юм шүү дээ.

КЮ: Аа, тийм үү? Та “Мөн адил” гэдэг их сургуульд сурсан юм уу? Ийм нэртэй сургууль байдаг юм уу?

ЧХ: Би яаж “мөн адил” гэдэг нэртэй сургуулийн хуваарь авсан, яаж геологич мэргэжилтэй болсон түүхийг чи сонирхож байгаа бол би ярьж өгч болно шүү! Намайг дунд сургуулиа төгсөж байх тэр үед хөдөөний дунд сургуулиудад гадаадын дээд сургуулийн хуваарийг цөөн тоогоор өгдөг болоод байсан юм. Тэгээд ихэнхи хүүхдүүд Монгол улсын их сургуульд элсэн ордог байв. Гадаадын дээд сургуулийн хуваарийг хамгийн сурлага сайтай хүүхдүүдэд өгдөг байв. Энэ асуудлыг хотод ч, хөдөөд ч ялгаагүй, яг адилхан шийдэж байсан юм. Тэр жил манай сургуульд гадаадын дээд, сургуулийн цөөн хуваарь өгсөн юм байж. Түүний нэгийг нь манай сургуулийн захиргаа надад өгхөөр шийдсэн юм. Танай Япон орны боловсролын тогтолцоо манайхаас өөр байх л даа. Тийм болохоор миний энэ яриа та нарт тийм ч их ойлгомжтой байж чадахгүй байж магадгүй. Тэр үед манайд бүх шатны боловсрол үнэ, төлбөргүй байлаа. Тийм болохоор хүүхэд өөрөө л сайн сурч чадах юм бол түүний өмнө их, дээд сургуулийн хаалга нээлттэй байв. Харин их, дээд сургуульд ороход “элсэлтийн шалгалт”-ийг бол заавал өгч байсан юм шүү. Тэр шалгалтанд тэнцвэл л их сургуульд ордог байв. Ингээд би 1957 оны зун анх удаа Улаанбаатар хотод ирж орж ирлээ.

Тэр үеийн Улаанбаатарыг өнөөгийнхтэй зүйрлэх юм биш өдөр, шөнө шиг ялгаатай байв. Гэхдээ хөдөөнөөс ирсэн надад тэр үеийн Улаанбаатар асар том хот шиг л санагдаж байлаа. Олон том, жижиг машинууд, автобуснууд сүлжилдэж давхиад л, засмал хар замын уулзварууд дээр

өнгийн гэрлүүд асдаг байлаа. Арван долоон нас хүртлээ ийм юмыг огт үзээгүй, үзэх нь битгий хэл бараг сонсож ч байгаагүй шахуу надад энэ бүхэн чинь ёстой гайхамшигтай санагдаж байв. Би чинь Улаанбаатарт анх ирээд гадуур явахаараа ааваасаа огт салдаггүй байв. “Төөрчихнө!” гээд л их айдаг байв.

Тэр үед гадаадын дээд сургуульд суралцах хүүхдүүдийн асуудлыг МАХН-ын Төв хороо өөрөө шууд хариуцаж байсан юм. Ингээд би аавыгаа дагаад МАХН-ын Төв хороон дээр ирлээ. Тэндээс гадаадын дээд сургуулиудад ямар мэргэжлээр суралцаж болох талаар мэдээлэл олж авлаа. Уул, уурхайн инженер, цахилгааны инженер, гурилын үйлдвэрийн инженер, мах, сүүний үйлдвэрийн инженер, геологч гэх мэт мэргэжлээр гадаадын дээд сургуульд суралцаж болохыг мэдэж авлаа. Ингээд ямар мэргэжлээр суралцах талаар бодож эхлэж байгаа юм. “Геологичийн мэргэжлээр бол ямар ч сургуульд явахгүй!” гэж шийдлээ. “Геологич гэдэг бол уул, усаар хэсээд байгаль дэлхийн эзэн лус, савдгийг уурлуулдаг ажил хийдэг!” гэж дотоо бодож байсан юм.

Монголчууд “байгаль дэлхийн эзэн, онгодууд байдаг. Тэднийг уурлуулж болохгүй. Уулын модыг дур зоргоороо огтлох, газар ухах, усанд бохир зүйлийг оруулах зэрэг үйлдэл хийвэл байгаль, дэхийн эзэн, онгодууд уурлаж, их цас орж зуд болно, эсвэл бороо хур орохоо больж ган болно, нутаг оронд өвчин зовлон гарч хүн ардын амьдрал хэцүү болно!” гэж итгэж байдаг юм шүү дээ. Олон зуун жил, магадгүй олон мянган жил манай энэ газар нутагт амьдарч байсан эртний хүмүүс ингэж итгэж ирсэн юм. Тэгээд жил бүр хавар, намарт байгаль, дэлхийн эзэн, онгодуудыг аргадаж “овоо тахих ёс”-ыг үйлдэж ирсэн юм шүү дээ. Та нар манай хөдөө орон нутгиар явдаг байх л даа. “Овоо” гэж юу байдгийг үзсэн байх. “Овоон дээр байгаль, дэлхийн эзэн онгодууд цуглаж ирдэг!” гэж монголчууд итгэж байж. Тэгээд тэд нарт зориулаад овоон дээр цагаан идээнийхээ дээжийг өргөдөг юм. Үүнийг “овоо тахих ёс” гэж нэрлээд байгаа юм шүү дээ. Эрт дээр үед “төрийн тахилгат овоо”-нууд байж. Тэнд улсын хаад, ноёд очиж овоо тахих ёс үйлдэж байж. Манайд социалист нийгмийг байгуулж байх үед “овоо тахих ёс” хориотой байв. 1990-ээд оноос хойш энэ уламжлал дахин сэргэж эхэллээ. Одоо манай улсын ерөнхийлөгч зарлиг буулгаад “төрийн тахилгат овоо”-нуудыг сэргээж эхлээд байна. “Хан Хэнтийн уулын овоо”, “Алтан овоо”, “Хан Хөхий уулын овоо”, “Суврага Хайрхан уулын овоо” зэрэг овоонуудад дөрвөн жил тутамд нэг удаа “төрийн тахилга” үйлддэг уламжлалыг сэргээгээд байна. Энэ бүгдэд манай ерөнхийлөгч, ерөнхий сайд болон бусад төрийн өндөр албаны хүмүүс байнга оролцож байна. Их талын нүүдэлчдийн байгаль, дэлхийгээ шүтэх, хайрлан хамгаалах уламжлал одоо ч манай

хүмүүсийн ухамсарт бөх баг оршсон хэвээрээ байгааг энэ бүхэн гэрчлэх байх.

Ингээд би “уул, уурхайн инженер” гэдэг мэргэжлийг сонгож авахаар шийдэж байлаа. Энэ мэргэжлийг сонгож авсан нь бас учир шалтгаантай юм аа. “Уул, уурхайн инженерийн мэргэжилтэй болчих юм бол Налайхын нүүрсний уурхайд ажиллах байх. Налайхын нүүрсний уурхайд ажилладаг болчихвол Сүхбаатар аймаг руугаа явахад зам дагуу, ойрхон юм!” гээд л бодож байлаа шүү дээ. Та нар Налайхын нүүрсны уурхай хаана байдгийг мэдэх байх л даа. Тэр бол Улаанбаатар хотоос зүүн тийш 45 км-ийн зайд оршдог шүү дээ. Хамгийн гол нь манай Сүхбаатар аймаг явах зам дагуу байдаг юм. Налайхын уурхай бол нүүрсний хамгийн ууган урхайнуудын нэг юм шүү дээ. Улаанбаатар хотыг нүүрсээр хангадаг гол уурхай л даа. 1922 онд Ардын засгийн газраас Налайхын нүүрсний уурхайг улсын үйлдвэрийн газар болгох шийдвэр гаргаж байсан юм билээ. 1945 онд Налайхын нүүрсний уурхай бүрэн хэмжээгээрээ ашиглалтанд орсон юм шүү дээ. Хожим “Шарын голын нүүрсний уурхай”, “Бага нуурын нүүрсний уурхай” гээд улсын хэмжээний олон том уурхайнууд ашиглалтанд орсон л доо. Одоо “Таван толгойн нүүрсний орд”-ыг ашиглах бэлтгэл ажил хийгдэж байна. Энэ бол коксжих нүүрснийхээ нөцөөр дэлхийн хамгийн том ордуудын нэг юм шүү дээ.

Ингээд л би аавыгаа дагуулаад МАХН-ын ТХ дээр дахин очлоо. Тэгээд “уул, уурхайн инженер” гэсэн мэргэжлийг сонгож аваад бүртгүүлчихлээ. Энэ мэргэжлээр зөвхөн ЗХУ-д суралцах юм байж.

Тэр үед гадаадын дээд сургуульд суралцах “сургалтын зардал”-ын асуудлыг хүүхдийн өөрийнх нь сонгож авсан мэргэжлийн дагуу төрийн нэг яам хариуцдаг байсан юм. Би “уул, уурхайн инженер”-ийн мэргэжлийг сонгож авсан тул миний сургалтын зардлын асуудлыг Аж үйлдвэрийн яам хариуцаж байгааг мэдэж авлаа. “Сургалтын зардал”-д сурч байх хугацаандаа жилд нэг удаа зуны амралтаараа Монголд ирэх, буцах замын зардал (галт тэргээр), сургалтын төлбөр, сард бүрийн оюутны степенди зэрэг зардлууд орж байсан юм. Бас сургуульд явах анхны жил суралцахад хэрэгтэй ойр зуурын зүйлүүдийг авах жаахан бэлэн мөнгө өгдөг байв. Ингээд би Аж үйлдвэрийн яаман дээр ирлээ. Тэнд Боловсон хүчний хэлтэст нь МАХН-ын Төв Хорооноос өгсөн бичгийг үзүүлээд дахиад бүртгүүлээ. Тэнд “Та нар 8 сарын 15-аас өмнө ирээрэй. Тэр үед суралцах сургуулийн нэр тодорхой болно! Одоо амарч болно!” гэж хэлсэн юм. Ингээд аав, бид хоёр нутаг буцахаар боллоо. Зун болоод, “Наадам” их ойртсон үе байлаа шүү дээ. “Наадам” бол монголын нүүдэлчин ардын хамгийн том баяр болохыг та нар мэдэх байх. “Наадам” болох өдрийг манайхан хоног тоолон хүлээж суудаг юм. Тэр үед аав, бид хоёр нутаг

буцаж, “Наадам”-аа хийхээр маш их яарч байснаа одоо би тодхон санадаг юм. Бид хоёрын хувьд гадаадад оронд явж, дээд сургуульд сурах нь их чухал боловч нутагтаа очиж “Наадам”-аар уралдуулах хурдан морио уях нь түүнээс ч дутахааргүй чухал ажил байсан байх аа. Миний аав хурдан моринд их дуртай хүн байв. Манайх жил бүрийн “Наадам”-аар их олон морь уяж уралдуулдаг, манай аавын уясан морьдууд голдуу л түрүүлдэг байв. Миний аав энэ талаараа нутагтаа их алдартай хүн байсан юм аа. Миний хувьд одоо аавынхаа тэр байранд ирчихээд байна. Би одоо жил бүр олон хурдан морь уядаг, миний уясан морьдууд “Надам”-д сайн давхиж байгаа. Би төрд алба хашиж байхдаа гадаадад их л явлаа, олон ч орны олон ч тансаг сайхан баяр, цэнгүүнийг үзлээ. Гэхдээ “Монгол наадам” арай л өөр шүү! Наадам болох өглөө ямар гоё байдагийг зөвхөн малын дэргэд төрж, мал маллаж өссөн монгол хүн л мэднэ. Ёстой гайхамшигтай. Одоо “Монгол наадам”-ыг ЮНЕСКО-гийн дэлхийн соёлын өвийн бүртгэлд оруулах асуудал яригдаж эхлээд байна. Энэ асуудалыг удахгүй зохих журмын дагуу шийднэ биз ээ.

Тэр үед манайхан их олон гэрээрээ нэг дор зусдаг байв. Дандаа ах дүү нараас бүрдсэн 7-8 айл “хот-айл” болоод нэг дор зусдаг байв. Айл бүр олон хүүхэдтэй, хамгийн олон хүүхэдтэй айлын хүүхдийн тоо арав гарч байсан байх шүү. Манай “хот айл”-ын нийт хүүхдийн тоо дөч хүрч байсан гэдэг юм. Тэгээд нутгийн ардууд манай хот айлыг “олныхон” гэж нэрлэдэг байв. Манайх 1000 гаруй хоньтой, 200 гаруй адуутай, 150-160 орчим тэмээтэй, бас хоёр зуу орчим үхэртэй айл байсан юм. Ингээд аав бид хоёр нутагтаа буцаж ирээд хурдан морио уялаа. Тэр жилийн “Наадам” ч мөн адил сайхан болоо, манай уясан морьдууд урьдын адилаар сайн давшилаа. Ингээд 8 сарын дундуур аав бид хоёр дахиад Улаанбаатар хотод ороод ирлээ. Тэгээд Аж үйлдвэрийн яаман дээр очлоо. Тэнд гадаадын дээд сургуульд явах хүүхдүүдэд ямар мэргэжлээр, аль улсын, ямар сургуульд сурах хуваарийг нь хэлж өгч байв. Яамны боловсон хүчний хэлтэсийн даргын өрөөнд хүүхдүүдийг нэрээр нь дуудаж оруулаад, аль улсын, ямар сургуульд сурах хуваарийг нь хэлж өгч байв. Намайг ороход тэнд бас 2-3 хүүхэд хүлээж байв. Би ч тэдний ард ороод л зогслоо. Эхний хоёр хүүхэд хуваариа аваад гараад явлаа. Түүний дараа “Дундговиос ирсэн Банзрагчийн Адъяа, Москвагийн Геологи, хайгуулийн дээд сургууль!” гээд дуудаж байна. Ингээд миний өмнө зогсож байсан хүүхэд тэр хуваарийг авлаа. Түүнийг өрөөнөөс гарч явсны дараа “Сүхбаатар аймгиас ирсэн Чойжингийн Хурц!!!” гээд дуудаж байна. Би урагш нэг алхаад зогстол “*мөн адил!*” гэж хэлэв. Ингээд би тэндээс гарлаа. Тэндээс гарч ирээд л “*Мөн адил* гэдэг нэртэй сургууль байдаг юм болов уу?” гээд гайхаад л бодож байлаа шүү дээ. Их л балчир байж дээ. Тийм байгаа биз?

Ингээд л гадаадад явах нь нэгэнт тодорхой байсан болохоор аав бид хоёр явах бэлтгэлээ хийж эхэллээ. Аж үйлдвэрийн яам бидэнд жаахан бэлэн мөнгө өглөө. Түүгээр нь би өөртөө өмсөх пальто, костюм, ботинки зэрэг зүйлүүдийг худалдаж авлаа. “Гадаадад монгол дээл өмсөж болохгүй!” гэж бодоод байсан байх л даа. Нутагтаа байхдаа би чинь ийм европ маягийн хувцас бараг өмсөж байсангүй. Ингээд нэг модон хайрцаг олж авлаа. Эрт дээр үеэс манай монголчууд алс холын газарт, олон сараар “тэмээн жин” тээгээд явдаг байлаа шүү дээ. Ингэж явахдаа хүмүүс нэг модон хайрцагт ойр зуурын хэрэгцээнийхээ зүйлийг хийгээд авч явдаг байсан юм. Тэр хайрцгийг “аяны хайрцаг” гэж нэрлэдэг юм. Аав бид хоёрын олж авсан хайрцаг түүнтэй л ижил хайрцаг байсан байх. Тэгээд би тэр модон хайрцагтаа худалдаж авсан зүйлүүдээ хийчихлээ. Бас түүнийгээ нэг шуудайд хийж байгаа юм. Алсын аян, жинд явах гэж байгаа юм шиг л юм болж байна шүү дээ. Би өөрөө ч тийм л төсөөлөлтэй байсан байх. Тэр үед дэлгүүрт чөмөдөн зардаггүй байсан юм болов уу даа, аав бид хоёр “барааны зах” дээрээс бас нэг жижигхэн чөмөдөн авлаа. Түүндээ арай илүү сайн хувцасаа хийж байгаа юм. Ингээд явах өдөр боллоо. Аав бид хоёр Улаанбаатарын вокзал дээр ирлээ. Тэр үед чинь такси их ховор байлаа шүү дээ. Бараг байхгүй. Автобус явдаг байсан. Гэвч автобус ирэхгүй, их удаан хүлээлгэдэг байв. Одоогийнхтой адил биш. Тэгээд аав бид хоёр вокзал руу явган явсан юм. Би “Миний аав ядарна!” гэж бодоод бүх ачаагаа өөрөө үүрээд явж байснаа одоо тодхон санаж байна. Биднийг ийнхүү явсаар вокзал ирэхэд тэнд маш олон хүн цугласан байв. Тэр үед гадаадад суралцахаар явж байгаа хүүхдүүдээ эцэг, эх, ах, дүү нар нь бүгдээрээ вокзал дээр ирж гаргаж өгдөг байлаа шүү дээ. Явах хүн, үдэж өгч байгаа хүмүүс нийлээд Улаанбаатар вокзал хөл тавих зайгүй болдог байлаа. Гадаадад хүүхэд нь суралцахаар явж байгаа айлд урд өдөр нь ах, дүү нар нь цуглараад хоол, унд бэлтгээд жижигхэн “найр” шиг юм хийдэг байв. Ингээд нөгөө явах хүүхэддээ бүгдээрээ захиа, сургаалиа хэлдэг байлаа. Ингэж их сүртэй үдэж өгдөг байсан юм. Гадаад оронд явж их, дээд сургуульд суралцана гэдэг чинь их нэр хүндтэй ажил байлаа шүү дээ. Хүүхэд нь гадаадын их, дээд сургуульд суралцахаар явна гэдэг бол тэр айлын амьдралд их том үйл явдал болж байв. 1990-ээд оны эхээр ЗХУ болон зүүн европын орнуудад өөрчлөн байгуулалт эхлэж, манай улстай тогтоосон харилцаанд ихээхэн өөрчлөлт орж эхэлсэн тэр үеэс манай залуучууд тийш явж суралцах нь эрс багассан юм шүү дээ. Одоо харин гадаадад сурдаг оюутны тоо их өсөөд байна. Гэхдээ одоо манай залуучууд голчлон барууны орнуудад улсын болон хувийн зардлаар сурдаг болжээ. Тэд нар гол төлөв онгоцоор явж байна. Улаанбаатараас шууд болон шууд бусаар аль ч улсад онгоцоор явах бүрэн боломжтой

болчихоод байгаа юм.

Тэр өдөр аав бид хоёр олон хүний дундуур, хөлсөө урсган зүгэж явсаар миний суух вагоны дэргэд арай чүү ирлээ. Тэнд Аж үйлдвэрийн яамны хүн ирчихсэн, явах хүүхдүүдийн овог, нэрийг нь дуудаад вагонд суулгаж байв. Тэр үед бидний явах галт тэрэгний билетийг Аж үйлдвэрийн яам худалдан авч өгсөн юм. Аав бид хоёр чагнаад л зогсоод байлаа. Тэгж байтал “Москва хотын Геологи, хайгуулийн дээд сургуульд суралцах Чойжингийн Хурц вагондоо суугаарай!” гээд чанга дуугар орилж байна. Ингэж би анх удаа “Геологи, хайгуулын дээд сургууль”-д суралцах болсноо мэдэж авч байсан юм. Ингэж миний “геологич” болох зам эхэлсэн юм даа. Одоо тэр үеэс хойш бараг тавин таван жил өнгөрчээ.

ИЛ: Анх Москвад очиход ямар санагдаж байв? Хэцүү байв уу?

ЧХ: Анх Москвад очиход их л сайхан байж дээ. Тэр аугаа том хотод сурч, амьдарч байсан үе маань холдох тусам л тэр үеийн сайхныг би одоо улам илүү мэдрээд байх шиг санагддаг юм. Ер нь хүний залуу нас сайхан шүү дээ! Анх удаа вагонд суугаад Москвагийн зүг хөдлөж байх үеийн их сайхан дурсамж үлдэж хоцорсон байдаг юм. Бид нар анх вагонд суухдаа цав цагаан цамцан дээр, зангиа зүүгээд, шив шинэ костюм ээ өмсөөд л сууж байлаа. Тэгээд л вагоныхоо цонхыг онгойлгоод, толгойгоо гаргаад л өдөржин юм харж явдаг байв. ЗХУ, түүний дотор Сибирь нутгийн амьдрал манай амьдралаас ер нь их өөр шүү дээ. Замд тааралдсан хот, тосгод, машин тэрэг, хааяа асар хурдтай зөрөх урт, урт галт тэрэгний цуваанууд, орос хүмүүс, нэг ч үг нь ойлгогдохгүй орос яриа гээд л ер нь үзсэн, харсан, сонссон бүхэн хачин сонин, содон байж билээ. Бид нар чинь ийм зүйлүүдийг анх удаа л өөрийн нүдээр үзэж, харж байгаа юм шүү дээ. Ингээд “Сибирийн төмөр зам”-аар таван өдөр явсаар Москвагийн Ярославын вокзал дээр буухад өнөө цав цагаан цамц, шинэ хувцас маань пад хар болсон байж билээ. Москвад ирсний дараа эхэн үедээ орос хэл мэдэхгүй мөн ч их “хөглөж” байлаа даа. Улаанбаатарт дунд сургууль төгссөн хүүхдүүдийн орос хэлний мэдлэг хөдөөний дунд сургууль төгссөн биднийхтэй харьцуулбал арай илүү байдаг юм. Намайг сургуульд сурч байхад бидэнд орос хэлийг заах багш манай аймагт байсангүй. Ингээд бид нар орос хэл бараг заалгалгүй дунд сургуулиа төгссөн юм. Биднийг Москва руу явахын өмнө “элсэлтийн шалгалт” авахаар боллоо. Тэр үед “Би 10 жил дараалан онц сурсан. Москвад очоод, орос хүмүүсийн дунд ороод, орос багшаар хичээл заалгаад, орос хэлийг аяндаа сурах биз! Энэ шалгалтанд орохгүй!” гээд л бодож байлаа шүү дээ. Их том зантай байгаа биз? Намайг дунд сургуулиа төгссөн тэр жил манай сургуулийг хоёр л хүн онц дүнтэй төгссөн юм. Түүний нэг би, нөгөө нь академич Д. Төмөртогоо юм шүү дээ. Та нар академич Д. Төмөртогоог бараг таних

байх даа. Монгол хэл судлалын сэдвээр олон сайхан ном бичиж хэвлүүлсэн, их том эрдэмтэн бий. Одоо тэрээр Монголын Шинжлэх ухааны академийн хэл, зохиолын хүрээлэнгийн захиралын албыг хашиж байна. Тэр үед элсэлтийн шалгалт өгөөгүй, эсвэл элсэлтийн шалгалтанд тэнцээгүй хүүхдийг гададын их сургуульд явуулдаггүй журамтай байлаа. Ингээд л би энэ шалгалтанд орохоор шийдлээ. Бид нар орос хэл, математикийн шалгалт өгсөн юм. Эхлээд орос хэлний шалгалт өглөө. Надтай хамт өөр таван хүн энэ шалгалтанд орсон юм. Тэдний дунд Ховд аймгаас ирсэн Чимэд гэдэг хүүхэд бид хоёр л дунд сургуулиа төгсөөд, шууд дээд сургуульд орох шалгалт өгч байсан юм. Тэдний нэг нь Баян-Өлгий аймгийн Үйлдвэрчний Эвлэлийн хорооны даргын алба хашиж байсан хүн байв. Тэр үед Монгол улсын их сургуулийн дэргэд ЗХУ-д суралцах хүүхдүүдэд зориулсан “орос хэлний бэлтгэл анги” ажиллаж байсан юм билээ. Бидэнтэй хамт шалгалтанд орсон нөгөө гурван хүүхэд нь энд суралцаад төгссөн байв.

Ингээд л шалгалтын танхимд ороод суучихлаа. Бидэнд “Замын тэмдэглэл” нэртэй зохион бичлэг хийх даалгавар өглөө. Би орсоор бараг нэг ч үг бичиж чаддаггүй байсан хүн шүү дээ. Ингээд юу ч бичилгүй хэсэг суулаа. Бусад хүмүүсийг хартал бүгд л юм бичээд байна. Зарим нь бүр тал хуудас биччихсэн сууж байна. Би тэднээс тусламж авах санаатай “Та нар бичээд дуусаж байна уу?” гэвэл тэдний нэг нь “Бараг дуусаж байна!” гэж хэлчихээд бичсэн зүйлээ надад харуулах янз алга аа. Түүнийг С. Чулуундорж гэдэг юм. Тэрээр хожим Гадаад харицааны яаманд маш олон жил ажилласан, манай улсын мэргэжлийн их сайн дипломатуудын нэг болсон хүн дээ. Нэг хэсэг хугацаанд Польш улсад Монгол улсыг төлөөлсөн Элчин сайдаар ажиллаж байсан юм. Ингээд л би суугаад байлаа. Бичих юм байдаггүй. Тэгж байтал шалгалтын цаг ч дууслаа. Тэгээд “Улаанбаатар” гэж бичээд түүнээс сум заагаад нөгөө үзүүрт нь “Москва” гэж бичээд өгчихлөө. Танхай байгаа биз? Ямар дүн авах нь тодорхой шүү дээ. Ингээд хэд хоногийн дараа математикийн шалгалтанд орлоо. Энэ чинь миний чаддаг ганц хичээл байлаа шүү дээ. Тэгээд л бүх бодлогоо шууд л бодчихлоо. Миний дэргэд суусан хүүхдэд би өөрийнхээ бодсоныг харууллаа. Тэр шууд л хуулаад бичиж байна. Гэтэл нөгөө талд суусан нөхдүүд “Бодсон уу?” гээд л асууж байна. Би ч “Бодчихсон!” гэж хариулчихаад л сууж байлаа. “Та нар орос хэлний шалгалтан дээр яалаа? Надад туслаагүй биз дээ?” гээд л дотроо бодож байлаа шүү дээ. Ингээд би математикийнхаа шалгалтыг “онцсайн” өгчихлөө. Ингэж миний өгсөн шалгалтын дүнгээр намайг “орос хэлний бэлтгэл анги”-д хуваарилсан юм.

Москванд ирсний дараа хамгийн хэцүүхэн байсан үе бол эхний хагас жил байв. Ёстой “адал явдал”-аар дүүрэн үе байсан даа. Одоо би

хүүхдүүддээ энэ тухай ярихаар тэд нар намайг шоолоод, хөхрөлдөөд, элгээ дарж унаад байдаг юм. Москвад очсоны дараахан нэг өдөр автобусанд суугаад явж байлаа. Автобус зогсоол дээр зогсохоор хүмүүс буугаад л байв. Тэр үед автобусны хойд хаалгаар нь ороод, урд хаалгаар нь буудаг байв. Одоо Москвад автобусны урд хаалгаар нь ороод, буцаад урд хаалгаар нь буудаг болсон байна билээ. Би автобусны жолооч зогсоолын нэрийг зарлахад өөрийн буух зогсоолын нэрийг бараг ойлгохгүй шахам л байлаа. Тэгээд автобусны цонхоор харж, буух буудал дөхөж байгааг мэдэж авдаг байв. Тэгээд л цонхоор хараад л явлаа. Миний буух буудал дөхөөд л байлаа. Тэгээд би буух гээд бэлтгэж байтал миний урд талд, миний буух замыг хаагаад, автобусны хоёр талын суудлын яг дунд нь нэг том биетэй, бүдүүн орос хүн зогчихлоо. Ер нь орос хүмүүс чинь өндөр нуруутай, их том биетэй хүмүүс байдаг шүү дээ. Монголчууд бол тэдэнтэй харьцуулахад жижиг биетэй, намхан нуруутай шүү дээ. Гэтэл би тэр хүнд нэг ч үг хэлж чаддаггүй. Уг нь бол “Би буумаар байна. Та зам тавьж өгнө үү?” гээд хэлчихэд л болно шүү дээ. Гэтэл би ингэж ч хэлж чаддаггүй. Тэгээд тэр хүн миний замаас холдохыг хүлээхээс өөр арга байдаггүй. Ингээд хүлээгээд л зогсоод байлаа. Ингэж байтал автобус миний буух ёстой зогсоол дээр ирээд зогслоо. Би нөгөө хүнийг араас нь аяархан түлхэв. Гэтэл тэр эргэж хараад “Что?” гээд ууртай асууж байна. Би өмнөөс нь “Аа, аа! Аа, аа!!!” гэхээс өөр нэг ч үг хэлж чаддаггүй. Тэгж байтал автобус ч хөдлөөд явчихлаа. Нөгөө орос над руу нэг том харснаа сая учрыг олсон бололтой “Извените!” гэж хэлээд, яльгүй инээмсэглээд зам тавьж өгөв. Гэтэл автобус байрнаасаа нэгэнт хөдөлсөн тул би бууж чадсангүй. Ингээд би нэг буудал өнгөрч яваад бууж байлаа.

Бас нэг өдөр үдийн цайны цагаар сургуулийнхаа хоолны газарт орлоо. Намайг ороход тэнд нилээд хүн дараалалд зогсож байв. Би ч тэндний ард очоод зогслоо. Тэр үед Москвад дэлгүүр, гуанз болон ер нь үйлчилгээний газруудад дараалал их үүсдэг байв. Би ч энд ирснээсээ хойш дараалалд зогсож овоо сураад байв. Ингээд “ямар хоол авах вэ?” гээд бодов. Гэтэл би нэг ч орос хоолны нэр мэддэггүй. Тэгээд хүмүүс юу хэлж байгааг чагнаад байлаа. Гэтэл хүмүүс “Дайте мне пожалуйста, шоссей!?” гээд хэлж байна. Ингэж хэлэхээр үйлчлэгч хүүхэн 2-3 ширхэг гожгор улаан юмыг тавган дээр тавиад өгч байна. Тэр хүмүүс яах ч аргагүй “шоссей!!!” гэж хэлээд байсан юм даа. Тэгээд би “Шоссей гэж юу вэ?” гээд л дотроо бодоод байлаа. Огт мэддэггүй. Ингээд миний хоол захиалах ээлж боллоо. Би “Дайте мне шоссей!” гээд л хэлчихлээ. Гэтэл үйлчлэгч хүүхэн над руу нэг том харснаа “Что вам надо?” гээд л дахин асууж байна. Тэгэхээр нь “Дайте мне ваши шоссей!” гээд би дахиад чангахан хэллээ. Гэтэл тэр зааланд хоол идээд сууж байсан оюутнууд

“нир” хийтэл зэрэг инээлдээд явчихлаа. “Оросоор цэвэрхэн, зөв хэлсэн шүү дээ! Яагаад намайг ойлгохгүй, шоолоод байгаа юм бол?” гэж би дотроо бодоод, өөрийгээ өмөөрөөд зогсож байв. Нөгөө орос хүүхэн чинь “Что ??? Шоссей ??? Какое вам шоссей ???” гээд л улам чангаар асууж байна. Тэгээд би нөгөө гожгор улаан юмнуудыг хуруугаараа заалаа. Гэтэл тэр үйлчлэгч “Это, что ли??? Это не шоссей!!! Это же сосиски!!!” гэж хэлээд нөгөө гожгор улаан юмыг сэрээгээр хатгаад аваад ирлээ. Орос хүүхнүүд чинь ер нь их нүүрэмгий хүмүүс байдаг юм шүү дээ. Өөрийнхээ бодсон зүйлээ бол шууд л хэлнэ, айдаг ч үгүй, ичдэг ч үгүй юм шиг. Бидэнтэй адилгүй. Дээр нь тэд нар чинь өндөр гоолиг нуруутай, их царайлаг, гоё хүмүүс байдаг юм аа. Гэтэл би чинь оросоор өөр үг хэлж мэддэггүй, өнөө гоё хүүхний чинь өмнө нэг их ээрч, муурсан, мунгинасан хүн зогсож байлаа шүү дээ. Тэнд байсан оюутнууд намайг шоолоод улам чанга, чанга хөхрөлдөөд байдаг, миний хамаг биений хөлс бурзайгаад байдаг. Үгүй, мөн ч хөглөж байлаа шүү. Гэтэл би “Сосиски” гэж хэлэхийг “Шоссей” гээд хэлчихсэн юм байж л дээ. Үүнийг би хожим ойлгосон юм. “Шоссей” гэдэг чинь бол монголоор “засмал зам” гэсэн утгатай үг юм. “Соски” гээд хэлчихсэн бол юу болох байсан юм бэ? Бүү мэд. “Соски” гэдэг бол хүүхдийн “угж” гэсэн утгатай үг л дээ. Нэг, хоёр үсгийн буруу дуудлагаас болоод үгийн утга ийм их өөрчлөгдөж байгаа юм шүү дээ.

Ер нь орос хэл сурч эхлэхэд үгийн дуудлага, өгүүлбэрийн интонаци гэдэг хоёр айхтар хэцүү зүйл байдаг юм. Орос хэл мэдэхгүй учир эхний үед иймэрхүү хөгтэй явдлууд их болж байлаа. Иймэрхүү байдалтайгаар эхний хагас жилийг өнгөрөөлөө. “Орос хэлний бэлтгэл анги”-ийг төгсөх үед бол бүр ч сайхан болоод, оросоор “хэрүүл хийх” хэмжээнд хүрсэн дээ. Ингээд дараа жил нь Москвагийн Геологи, хайгуулийн дээд сургуулийн нэгдүгээр курсийн оюутан боллоо. Энэ сургуульд би “онц”, “сайн” дүнтэй сурсаар төгссөн юм аа. Манай сургуульд С. Н. Бермин гэсэн автортой “Математикийн бодлого”-ын сурах бичгийг хэрэглэдэг байв. Түүнд 400 гаруй бодлого багтаж байсан юм. Би түүнийг надтай хамт ирсэн нэг оюутантай хамт бодлоо. Тэнд байсан бодлогуудыг бүгдийг нь бодоод дуусгахад дөрвөн зузаан дэвтэр дуусаж байсан юм. Ингээд энэ дэвтрүүд маань манай сургуулийн оюутны байрны өрөөнөөс өрөө дамжаад л явдаг байлаа шүү дээ. Нэг үгээр хэлбэл “математикийн хичээлийн гарын авлага” болчихсон юм. Манай сургуульд Монголоос надаас гадна 30 оюутан сурч байв. Би чинь өөрийн сурч байгаа сургуулийнхаа “Монгол оюутны зөвлөл”-ийн даргаар сонгогдон ажиллаж байлаа. Бас Москвад сурч байгаа нийт “Монгол оюутны зөвлөл”-ийн тэргүүлэгч гишүүнээр сонгогдлоо. Мөн Москвагийн монгол оюутны “Хувьсгалт залуучуудын

эвлэл”-ийн хорооны тэргүүлэгч гишүүнээр сонгогдон ажиллаж байв. Энэ үед би МАХН-д гишүүнээр элсэж байв. Ингэж би оюутан байх хугацаандаа оюутны олон нийтийн ажилд маш идэвхтэй оролцдог байлаа. Намайг оюутан байх хугацаанд манай сургуульд сурч байсан зарим оюутан шалгалтаа өгч чадалгүй сургуулиасаа хасагдах явдал гардаг байв. Тэгээд би сургуулийнхаа “Монгол оюутны зөвлөл”-ийн даргаар сонгогдсоны дараа нэг удаа сургуулийн захиралтай уулзаж энэ асуудлаар ярилцсан юм. “Манай улсад өнөөдөр геологийн мэргэжилтэн их хэрэгтэй байна. Манай сургуульд сурч байгаа зарим оюутнууд шалгалтаа өгч чадалгүй сургуулиас хасагдах явдал гараад байна. Тухайлбал, “начертательный геометр” гэдэг хичээлийн шалгалтыг зарим хүүхэд өгч чадахгүй байна. Үүнд учир шалтгаан байна. Монголд дунд сургуульд сурч байхдаа ийм хичээл үзэж байгаагүй болохоор оюутнуудын бэлтгэл сайнгүй байна. Та энэ байдлын талаар багш нарт тайлбарлаж өгнө үү! Манай оюутнуудаас шалгалт авахдаа энэ учир шалтгааныг харгалзан үзэх боломж байна уу?” гэсэн асуудлыг түүнд тавьсан юм. Түүнээс хойш манай сургуулийн захирлын шийдвэр гарч энэ хичээлийг монгол оюутнуудад тусгай хөтөлбөрөөр заах болсон юм. Түүнээс хойш манай сургуулиас шалгалт өгч чадаагүй шалтгаанаар оюутан хасагдах асуудал байхгүй болсон доо. Тэгээд бид нар тэр жил 8-уулаа сургуулиа төгсөж байлаа.

3. Засгийн газрын дэргэдэх “Геологийн хайгуул, шинжилгээний газар”-т

Сургуулиа төгсөөд Монголдоо ирлээ. Тэр үед Монгол улсын их сургуульд “Геологи, хайгуул шинжилгээний анги” шинээр нээгдээд байв. Надтай хамт манай сургуулийг төгссөж ирсэн Д. Төмөртогоо бид хоёр тэнд багшаар очих сонирхолтой байв. Тэр үед ЗХУ болон бусад гадаад орнуудад их, дээд сургууль төгссөн хүмүүсийн ажиллах газрын хуваарийг мөн л МАХН-ын ТХ шийддэг байв. “Сургуулиа сайн сурч төгссөн, ийм сурлага сайтай хүмүүсийг Их сургуульд өгөөд байж байж болохгүй. Үйлдвэрлэл дээр бас сайн хүмүүс очиж ажиллах ёстой!” гэсэн яриа МАХН-ын ТХ дээр гарсан юм билээ. Ингээд МАХН-ын ТХ-ны шийдвэр гарч би Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх “Геологийн хайгуул, шинжилгээний газар”-т ажиллахаар болж, харин Д. Төмөртогоо маань багш болж байлаа.

Ингээд би ажиллах газраа очлоо. Тэр үед “Геологийн хайгуул, шинжилгээний газар”-ын даргаар Маамжавын Цэрэндорж гэдэг хүн ажиллаж байсан юм. Тэнд Монгол улсын их сургууль төгссөн арван нэг, Чех улсад их сургууль төгсөөд ирсэн долоо, ЗХУ-д сургууль төгсөөд ирсэн долоо, нийт хорь гаруй мэргэжилтэн ажлаж байв. Мөн ЗХУ-аас

ирсэн мэргэжилтнүүд ажиллаж байв. Тэндээс жил бүр “Геологи хайгуулын анги”-ууд хөдөө орон нутаг томилогдон ажилладаг байлаа. Нийтдээ 2-3 ийм хайгуулын анги байсан байх. Нэг ангид ЗХУ-аас ирсэн дөрвөөс доошгүй мэргэжилтэн ажилладаг журамтай байв. Би ажилдаа ороод удаагүй байтал нэг өдөр манай дарга “Би удаагүй геологийн хайгуулын ангиудаар явж ажил байдалтай нь танилцах бодолтой байна. Чи хамт явна шүү!” гэж хэлсэн юм. Ингээд түүнээс хойш удалгүй дарга бид хоёр хамт геологи, хайгуулын ангиудаар явлаа. Тэр үед чинь ЗХУ-аас ирсэн мэргэжилтнүүдийг бурхан шиг л шүтдэг үе байлаа шүү дээ. Тэдний дунд үнэхээр мэдлэг, мэргэжил сайтай олон хүн ирж байсан юм аа. Түүнээс гадна бас нилээдгүй үзэл суртал явагдаж байсан юм. Зөвлөлтийн мэргэжилтний үгийг сонсохгүй, өгсөн зөвлөлгөөг нь авахгүй бол “Зөвлөлтийн эсрэг үзэлтэн”, эсвэл “Монгол-Зөвлөлтийн их найрамдалд дайсагнагч этгээд!!!” гэсэн нэр, хочтой болоод шийтгүүлэх ч явдал багагүй гарч байсан юм. Ингэж геологийн хайгуулын ангиудийн ажил байдалтай нь танилцаад явж байх үед тэнд ажиллаж байгаа ЗХУ-аас ирсэн мэргэжилтнүүдтэй геологийн хайгуулын талаар санал солилцох боломж надад олдсон юм. Зарим үед тэдэнтэй ширүүн маргаан өрнүүлэх явдал гарах болов.

Учир нь тэдний зарим нь геологийн хайгуулын ажил болон ер нь эрдэс баялагийн талаар тунчиг дульхан мэдлэгтэй болох нь харагдаад байв. Би энэ талаар нэг жишээ хэлье л дээ. Вольфрам гэдэг химийн элемент байгаль дээр дангаараа байдаггүй шүү дээ. Түүнийг өөр бусад элементүүд заавал л дагалдаж байдаг юм. Түүнийг ямар элементүүд дагалдаж байдаг нь тов тодорхой байдаг юм. Геологийн мэргэжилтнүүд тэр элементүүдийг шууд л нэрлэж чадна. Гэтэл ЗХУ-аас ирсэн мэргэжилтнүүдийн зарим нь “Үгүй, тийм биш, вольфрамыг ийм элементүүд дагалддаг гэж би сонсоогүй!” гэх зэргээр надтай маргалддаг байв. Зөвхөн вольфрам ч биш байгаль дээр байдаг олон эрдэс бодисийн дагалдах элементүүдийг тэдний зарим нь огт мэдэхгүй, эсвэл бүдэг бадаг л мэдэж байв. Тэгээд л надтай маргалдаад эхэлж байгаа юм. Би тэдэнтэй маргалдаад эцэстээ тэд нар өөрсдөө мэдэхгүй байгаа нь нотлогдоод “бууж өгдөг” болов. Тэдний нэг нь ч, нэг ч монгол үг мэдэхгүй шүү дээ. Бид нар чинь орос хэл дээр л маргалдана шүү дээ. Тэр үед хайгуулын ангиудад ажиллаж байсан зарим монгол мэргэжилтнүүд “Хүүе, Хурц аа, чи боль! Ингэж ярьж болохгүй! Чи зөвлөлтийн мэргэжилтнүүдтэй маргалдаж, тэднийг мэдлэг, мэргэжилгүй гэж ярьж ерөөсөө болохгүй! Чи улс төрийн хэрэгт орно шүү!” гэж хэлж байсан юм. Тэдний энэ үгийг сонсоод “Үнэн байх шүү! Улс төрийн хэрэгт орж магадгүй юм!” хэмээн би дотроо бодож байсан юм. Тэгээд надтай хамт ирсэн даргынхаа дэргэд тэдэнтэй маргаан

хийхгүй байхыг хичээдэг болов. Тэр үед “Манай дарга юу гэж хэлэх бол?” гээд жаахан айж байсан байх л даа. Гэтэл манай дарга энэ асуудлын талаар огт өөр бодолтой байгаа нь удахгүй тодорхой болов. Тэрээр манай геологчдод “Мэргэжилтэн гэж ийм өргөн мэдлэгтэй хүнийг хэлдэг юм!, Геологийн мэргэжилтэн чинь ийм байх ёстой юм шүү дээ! Та нар энэ залууг харцгаа! Ямар байна? Та нар орос хэлээр энэ залуу шиг ярьж сурах хэрэгтэй!” гэж ярьдаг болсон юм. Түүний энэ үгийг сонссон би гэдэг хүн чинь бүр “хамраа сөхөөд”, мээсийж байлаа шүү дээ.

Ингээд манай дарга бид хоёр энэ ажлыг дуусгаад Улаанбаатар хотод буцаад ирлээ. Гэтэл түүнээс хойш тун чиг удалгүй намайг “Геологийн шинжилгээний газар”-ын эдийн засгийн төлөвлөлтийн хэлтэсийн даргаар томилсон шийдвэр гарсан байв. Ингээд энд ажиллаад нэг жил зургаан сар орчим болж байтал Засгийн газрын шийдвэр гарч “Геологи, уул уурхайн яам” байгуулагдсан юм. Түүнийг манай “Геологийн хайгуул, шинжилгээний газар”-ыг өргөжүүлэх замаар байгуулахаар шийдвэрлэсэн байв. Геологи, уул уурхайн яам байгуулагдсан нь миний амьдралын бас нэг шинэ үеийн эхлэл болсон юм аа. Манай яамны сайдаар М. Цэрэндорж гуай ажиллахаар болов. М. Цэрэндорж гуай өөрөө геологич мэргэжлийн хүн биш боловч манай яамны өмнө тавигдаж байгаа асуудлуудыг сайн ойлгодог, удирдах ажлын арвин их туршлагатай, хүнлэг сайхан сэтгэлтэй, ажилч хичээнгүй хүн байсан юм. Би яамныхаа эдийн засгийн төлөвлөлтийн хэлтэсийн даргын албыг хашихаар болов. Энэ бол “Геологийн хайгуул, шинжилгээний газар”-г миний хийж байсан ажил юм л даа. Үүний зэрэгцээгээр Геологи, уул уурхайн яамны “ерөнхий геологч” гэсэн албан тушаалыг бас давхар хаших болов. Тэнд ажиллаж эхэлсэн эхний үед мөн л “хөгтэй хөгтэй явдал”-ууд олон болдог байв. Нэг өдөр М. Цэрэндорж сайд “За, Хурц аа, чи нэг тушаал төлөвлөөд ир!” гэж байна. Тэгээд М. Цэрэндорж сайд тушаалын агуулгыг надад товч хэлж өгөв. Геологийн хайгуулын нэг ангийн дарга ажлын алдаа гаргажээ. Тэгээд түүнийг энэ ажлаас нь халаад, өөр ажилд томилохоор шийдсэн юм байж. Тэр хүн Геологийн хайгуулын ангийн ажлыг олон жил удирдсан, удирдах ажлын арвин их туршлагатай хүн байсан тул түүнийг Геологийн яамны харъяа авто баазын даргаар томилохоор шийдээд байсан юм байж. Би ийм агуулгатай тушаал төлөвлөхөөр болов. Ингээд би тушаал төлөвлөж бичлээ. Түүнийгээ бариад сайдын өрөөнд дахиад орлоо. М. Цэрэндорж сайд миний төлөвлөсөн тушаалын төслийг аваад анхааралтай уншиж байна. Тэгээд юу ч хэлэлгүй намайг нэг хэсэг харснаа:

- За, чи чинь тушаал ингэж төлөвлөдөг хүн үү? Энэ чинь нэг хүнийг ажлаас нь халаад өөр нэг ажилд томилж байгаа тушаал шүү дээ. Тийм биз? гэж асууж байна. Би түүнд:

- Тийм ээ! гэж хэлчихээд сууж байлаа.

Гэтэл тэр:

- Тэгвэл чи яагаад түүнийгээ бичээгүй юм бэ? Чи ер нь юу бичээд ирсэн хүн бэ? Би чамайг ийм холион бантан болсон юм бичээд ир гэж хэлээгүй шүү! гэж ширүүхэн хэлж байна. Тэгснээ:

- Чи чинь ер нь монгол хүн юм уу? Орос хүн юм уу? Чиний энэ бичсэн зүйл дотор нэг ч монгол өгүүлбэр алга! Май, чи үүнийгээ аваад яв! Миний хэлсний дагуу дахин төлөвлөөд аваад ир! гээд тэр тушаалын төслийг надад эргүүлээд өглөө. Сайдаас гэнэт ийм хатуу шүүмжлэл сонссон би түүний өрөөнөөс хурдхан гарлаа. Ингээд өрөөндөө ирээд нөгөө тушаалын төслийг дахиад нэг уншиж үзлээ. Үнэхээр сайдын хэлдэг үнэн байна. Утга санаа нь тодорхой биш, ёстой л “холион бантан” болсон байв. Ингээд би түүнийг дахин бичихээр шийдлээ. Ингэж бичихийн өмнө үүнтэй ижил, төстэй асуудлаар манай яамнаас гаргаж байсан хуучин шийдвэрүүдтэй танилцаж үзлээ. Ингээд л бичиж эхэллээ дээ. Ажил тарсны дараа өрөөндөө ганцаараа үлдээд, хаалгаа сайтар хааж байгаад бичсэн зүйлээ ганцаараа чанга, чанга уншиж хүртэл үзсэн юм. Тэгээд л засаж, бичээд байлаа даа. Иймэрхүү байдлаар дахин дахин уншиж үзлээ. 4-5 удаа хуулбарлаж бичсэн шиг санагдаж байна. Үүний дараа сайдын өрөөнд дахиад орлоо.

М. Цэрэндорж сайд миний бичсэн зүйлийг анхааралтай уншиж байна.

Тэгээд:

- За болсон байна! гэж хэлэв.

Тэгээд намайг хэсэг харж байснаа:

- Чи нэг тушаал төлөвлөхөд ийм их цаг зарцуулж болохгүй! Цаашдаа чиний хариуцаж ажиллах олон асуудал бий! Ийм байж хэрхэвч болохгүй! Чи Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ажиллаж байгаа мэргэжлийн геологич хүн шүү дээ! Яамныхаа дотоод ажилтай хурдан танилцаж, өөрөө энэ ажлыг гардан хийж сурах хэрэгтэй! Эндээс гарч байгаа шийдвэр бүр Монгол улсын хууль, дүрэмтэй нийцэж байх ёстойг ямагт анхаарч байх хэрэгтэй! Мөн эндээс гарч байгаа шийдвэр бүр Монгол улсын геологи, уул уурхайн салбарын хөгжлийн хувь заяатай шууд холбоотой байдаг учраас том, бага гэлтгүй асуудал бүрт маш хариуцлагатай хандаж байх хэрэгтэй! гэж ширүүхэн хэлж байсан юм.

Ингэж би сайдаас өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлэх гээд “хөглөж” байв. Тэр үед манай яаманд хариуцсан ажлаа арван хуруу шигээ мэддэг, ажлын арвин их туршлагатай олон сайхан хүн ажиллаж байсан нь надад цаашдаа маш их хэрэг болж билээ. Сургууль төгсөж ирээд удаагүй байсан

би ямар ч асуудлаар ямар ч үед тэд нараас тусламж, дэмжлэгийг авч чаддаг байсан болохоор эдгээр хүмүүсийг би одоо ч талархан дурсаж явдаг юм аа. Би ийм байдлаар ажиллаж байтал намайг Гелог, уул уурхайн яамны орлогч сайдын албан тушаалд томилсон шийдвэр гарлаа. Өөрөөр хэлбэл миний хашиж байсан эдийн засгийн төлөвлөлтийн хэлтэсийн даргын албан тушаалыг маань яамны орлогч сайдын статустай болгох шийдвэр гарсан юм. Тэр үед би 26 настай байсан. Үүнээс хойш удалгүй бас дахин нэг томоохон албан тушаалд томилогдов. Энэ нь “МАХН-ын ТХ-ны гишүүн” гэсэн албан тушаал байв. Тэр үед МАХН бол 10 гаруй мянган гишүүнтэй, төрийн бүх эрх мэдлийг гартаа барьсан улс төрийн маш хүчирхэг хүчин байлаа шүү дээ. Харин МАХН-ын ТХ-ны гишүүн 100 орчим хүн байсан байх. Түүний нэг нь 26 настай би болж байгаа юм шүү дээ. Удалгүй бас Улаанбаатар хотын 10-р тойргоос сонгогдоод, Ардын Их Хурлын депутад болов. Мөн Монголын Хувьсгалт Залуучуудын Эвлэлийн Төв Хорооны Товчооны гишүүнээр сонгогдлоо. Би чинь богинохон хугацаанд ийм олон албан тушаалтай болж байв аа. Энэ үед анх удаа албан тушаалын олноос “айх” сэтгэгдэл төрж байлаа. Би чинь Геологи, уул уурхайн яамны орлогч сайдын албан тушаалыг 1976 он хүртэл хашаад, 1976-1980 онд энэ яамныхаа сайдаар томилогдон ажилласан хүн юм шүү дээ. Үүний зэрэгцээгээр Эдийн Засгийн Харилцан Туслалцах Зөвлөлд бүх социалист орнуудын геологи, уул уурхайн салбарын хамтын ажиллагааны асуудал эрхэлсэн нарийн бичгийн даргын албыг хашиж байв.

Үүний дараа Монгол улсаас ЗХУ-д суугаа элчин сайдын яаманд геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн нарийн бичгийн даргын албанд томилогдсон юм.

Геологи, уул уурхайн яамны сайд, орлогч сайдын албыг хашиж байх үед долоо хоногийн бараг таван өдөрт нь ямар нэгэн хуралд суух хэрэгтэй болдог байв. Гэхдээ миний үндсэн ажил бол Монгол улсын Геологи, уул уурхайн салбарын бодлогыг тодорхойлж, түүнийгээ хэрэгжүүлэх ажил байна шүү дээ. Энэ ажлаа бол би ёстой “өөрийн санаснаар” хийж эхэлсэндээ. Энэ үед манай улс Геологи, уул уурхайн салбарын хөгжилд онцгой анхаарал хандуулж эхлээд байв. 1961 оны 7-р сар хуралдсан МАХН-ын 14-р Их хурлаас геологи, уул уурхайн салбарыг хөгжүүлэх 10-15 жилийн төлөвлөгөөг боловсруулах их том зорилтыг дэвшүүлэн тавиад байв. Ер нь тэр үед ганц Монгол орон биш, бүх социалист системийн орнууд геологи, уул, уурхайн салбараа хөгжүүлэх томоохон зорилт тавиад ажиллаж эхлээд байсан юм шүү дээ. Энэ салбарт социалист орнуудын хамтын ажиллагаа ид өрнөж эхлээд байв. Намайг яаманд ажиллаж эхлээд байсан үе бол ийм их сонирхолтой, их ажлын үе байлаа.

4. Уул, уурхайн салбар дахь Зөвлөлт–Монголын хамтын ажиллагаа

КЮ: Тэр үед Монгол улс геологи, уул уурхайн салбарт ямар ямар орнуудтай хамтран ажиллаж байсан юм бэ?

ЧХ: Олон оронтой хамтын ажиллагааг өрнүүлж байсан. Гэхдээ тэр үед манайхтай энэ салбарт хамтран ажиллаж байсан орнууд бол бүгд социалист орнууд байсан бөгөөд түүний дотор ЗХУ тэргүүлэх байр суурийг эзлэж байв. Манай улс 1962 онд Эдийн Засгийн Харилцан Туслалцах Зөвлөлийн гишүүнээр элссэн явдал нь геологи, уул уурхайн салбарт социалист орнуудтай хамтран ажиллах аятайхан боломжийг нээж өгсөн юм.

ЗХУ бол геологи, уул уурхайн салбарын хөгжлийн түвшингээрээ дэлхийн тэргүүлэх орнуудын тоонд орж байв. ЗХУ-д геологи, уул уурхайн салбар бүр Октябрийн хувьсгалаас өмнө их хүчтэй хөгжиж эхэлсэн байдаг юм. Орос орны нутаг дэвсгэрт “Мендлеевын үелэх системд орсон бүх элемент бий!” гэсэн яриа байдаг юм. Энэ бол үнэнд их ойрхон яриа. Оросын шинлэх ухааны академийг үндэслэн байгуулагчдын нэг, их эрдэмтэн М. В. Ломоносов “Орос орны мандал, бадралын үндэс нь Сибирь нутагт бий!” гэж хэлсэн нэг үг бий. Та нар энэ үгийг уншсан байж болох юм. Сибирь бол үнэхээр байгалын баялаг арвин ихтэй бүс нутаг юм шүү дээ. Энд алмаз, алт, мөнгө зэрэг байгалын ховор элементээс гадна нефть, чулуун нүүрс, төмрийн хүдрийн асар их нөөц бий. Орос орон коммунист нийгэм байгуулах оролдлогыг хийж байх хугацаандаа техник, технологийн хөгжлийн зарим салбарт өрнөдийн орнуудаас хоцорсон явдал бий.

Одоо орос орон энэ хоцрогдолоо эрдэс баялагийн олдворлолтоороо нөхөх оролдлогыг хийж байна. Сибирь нутгиас олдворлож байгаа нефть, байгалын хий өнөөдөр Орос орныг дэлхийн эдийн засгийн хүчирхэг гүрнүүдийн түвшинд хүргээд байгааг бид хараад сууж байна шүү дээ. Тийм учраас бидэнд тэр үед ЗХУ-аас суралцах, туршлага судлах болон санхүүгийн тал дээр дэмжлэг авах зүйл их байсан, одоо ч байсаар л байна. Гэхдээ зарим үед манай эрх ашигт нийцэхгүй асуудлуудыг тэдний зүгээс тавьдаг, хийдэг байв. Ийм тохиолдолд тэдэнтэй ярилцаж, асуудлыг хоёр талын эрх ашигт нийцүүлэх шаардлага зайлшгүй гардаг байв. Тухайлбал, намайг геологи, уул, уурхайн яаманд ажиллаад удаагүй байтал ЗХУ-аас “Ураны хайгуулын анги” ирэв. Гэтэл тэдний монгол нутаг дээр хийх ураны хайгуулын бүх зардлыг монголын тал хариуцах ёстой юм гэнэ ээ. Би маш их гайхаж байгаа юм. Тэд нар “Энэ чинь Засгийн газар хоорондын хэлэлцээрээр шийдэгдсэн асуудал шүү дээ!” гэж хэлж байв. Би тэдэнд “Тэнд энэ асуудал яригдсан байж болно. Гэхдээ танайд уран

хэрэгтэй болоод түүнийгээ монгол нутгаас хайж олохоор шийдсэн юм бол энэ ажлынхаа зардлыг танайх өөрөө хариуцах хэрэгтэй! Бид нар ийм ажилд зардал гаргахгүй ээ!” гэж хэлж байсан юм. Тэгээд дараа жилийн улсын төсөв батлахад “Ураны хайгуулын ажил”-д нэг ч төгрөг төлөвлөлгүй орхиж байлаа. Гэтэл энэ асуудлаар намайг шүүмжлээд нилээд “шуугиан” дэгдэв. Тэгээд би “Монгол–Зөвлөлтийн найрамдал гэх мэт үзэл, сурталын асуудал надад хамаагүй! Би бодит байдалд л тулгуурлаж л шийдвэр гаргана! Хоёр сая хүрэхгүй хүн амтай, ийм сул эдийн засагтай Монгол мэтийн жижиг орон ураны хайгуулыг өөрийн зардлаар хийдэггүй юм!” гэж хэлдэг байв. Одоо бодоход би зарим үед тэд нартай арай хатуу ширүүн харьцдаг байсан юм шиг байгаа юм. Тэр үед Зөвлөлт–Монголын геологи, уул уурхайн салбарын хамтын ажиллагааны асуудлыг хариуцсан “Новосибирский совет” гэдэг нэртэй газар Новосибирск хотод ажиллаж байв. Түүний хуралд би байнга оролцдог байв. Тэр хурал дээр ч би хатуухан үг олныг хэлсэн дээ. Тэр үед Дорнод аймагт манай геологийн хайгуулын нэг анги ажиллаж байв. Тэр ангийн өмнө болор хайж илрүүлэх зорилго тавьсан байв. Болор бол байгаль дээр элбэг байдаг эрдэс баялаг биш л дээ. Тэр бол бүх төрлийн дурангийн сайн чанарын линзүүд болон гоёл, чимэглэлийн зориулалт бүхий сайн чанарын шил хийхэд ашиглагддаг үйлдвэрлэлийн өндөр ач хобогдолтой эрдэс баялаг боловч байгаль дээр ховор байдаг юм. Улаанбаатарын зүүн талд байдаг “Тэрэлж амралт-жуулчлалын газар”-ын наад талд “Горхи” гэдэг газар бий. Тэнд “Болор баяжуулах үйлдвэр” ажиллаж байв. Эндээс жил бүр ЗХУ-д сайн чанарын болорын баяжмал нэг тоннийг нийлүүлдэг байв. Энэ бүх ажилд Монгол улсын төсвөөс жил бүр 12 сая төгрөг зарцуулж иржээ. ЭНэ бол тухайн үеийн ханшаар бага зардал биш. Би дэлхийн зах зээл дээр нэг тонн болор ямар үнэ, ханштай байгааг судлаж үзлээ. Гэтэл ЗХУ-д нийлүүлж байсан болорын нэг тонн тутамын үнийг дэлхийн зах зээлийн үнэнээс нэг мянга дахин багаар тогтоогдсон нь тодорхой боллоо. Нэг мянга дахин бага гэдэг чинь бол үнэгүй авч байна л гэсэн үг шүү дээ. Ийм байж яасан ч болохгүй нь тодорхой байгаа биз дээ? Ингээд би энэ асуудлаар МАХН-ын ТХ-нд захидал бичихээр шийдэж байлаа. Түүндээ ЗХУ-д нийлүүлж байгаа нэг тонн болорын үнэ буруу тогтоогдсон байгаа талаар бичээд энэ байдлыг яаралтай засаж залруулах санал тавьсан юм. Би энэ захидлаа бас “Улсын төлөлөгөөний комисс”-г танилцууллаа. Энд миний саналыг их сайн хүлээж авлаа. Ингээд “Улсын төлөлөгөөний комисс “1964-1965 оны улсын төсөв батлахад Болор хайх хайгуулын болон болорын баяжмал үйлдвэрлэх зардлыг нь хасчихлаа. Уг нь бол энэ асуудлаар МАХН-ын ТХ-ны шийдвэр гарсны дараа “Улсын төлөлөгөөний комисс” шийдвэрээ гаргах ёстой байсан байх. Гэтэл тэгсэнгүй. Энд ч бас ийм “шудрага биш явдал” болж

байгааг харж л байсан байх л даа.

Манайд ЗХУ-аас ирж байсан зарим мэргэжилтнүүдийн дунд үнэхээр мэдлэг мэргэжил нь сул дорой хүмүүс ч цөөнгүй ирдэг байв. Тийм үед би тэдний хйагуулын ажлын төлөвлөгөөг нь батлаж өгөхөөс татгалздаг байв. Заримд нь “Чиний хийсэн хайгуулын ажлын төлөвлөгөө буруу байна. Би ийм төлөвлөгөө батлахгүй!” гэж хэлдэг байв. Тэгээд тэдэнд хайгуулын ажлын төлөвлөгөөг өөрөө хийж өгөөд “За, чи энэ төлөвлөгөөр ажиллаарай! Үүнээс өөр төлөвлөгөөр ажиллах юм бол чиний ажил үр дүнд хүрэхгүй шүү!” гэж хэлдэг байв. Иймэрхүү байдлаар ажиллаж эхлээд байтал энэ асуудлаар дахиад л “шуугиан” дэгдэв ээ! “Хурцыг ирснээс хойш ЗХУ-тай геологи, уул уурхайн салбарт хамтарч ажиллах боломжгүй боллоо! Тэр зөвлөлтийн мэргэжилтнүүдийг мэдлэг, мэргэжил муутай хэмээн ярьж, тэдэнд янз бүрийн хэлбэрээр даралт, шахалтыг үзүүлж, тэднийг хавчин гадуурхаж байна!” гэсэн утгатай яриа дэгдэж эхлэв. Энэ яриа ер нь зогсох янзгүй болоод ирлээ. Тэгж байтал нэг өдөр М. Цэрэндорж сайд намайг өрөөндөө дуудсан байв. Ямар асуудлаар дуудаж байгааг нь таамаглаж байсан болохоор сайдын өрөөнд би хурдхан очлоо. Намайг ороход сайд юм бичээд сууж байв. Тэр надад юм хэлсэнгүй, хэсэг хугацааны дараа тэр:

- За, чи чинь юу хийгээд байгаа хүн бэ? гэж асууж байна.

Би түүнд болсон явдлуудыг тайлбарлах гэтэл тэр:

- Гадуур яригдаад байгаа бүх асуудлыг би сонсож, мэдэсэн.

Чи ийм байдлаар энэ яаманд ажиллаж болохгүй! Чи зөвлөлтийн мэргэжилтнүүдтэй хэтэрхий ширүүн харилцаж байна. Тэднийг чи мэдлэг, мэргэжил муутай хэмээн ярьж болохгүй! Чи өөрөө ЗХУ-д очиж сургуульд нь суралцаад ирсэн хүн шүү дээ! Одоо энэ яриагаа яаралтай зогсоох хэрэгтэй! гэж тэр хэлэв.

Тэгээд би:

- Сайд аа, манайд ирсэн зөвлөлтийн геологи, уул уурхайн мэргэжилтнүүд дунд үнэхээр мэдлэг, мэргэжил муутай хүмүүс олон байна. Тэдний дунд бүр техникум төгссөн хүн “судалгааны инженер” гэсэн статустайгаар хүртэл ирж байна шүү дээ. Тийм хүмүүс хайгуулын ажлын төлөвлөгөө хийж чадахгүй байна. Хийсэн төлөвлөгөө нь маш их алдаатай болж байна. Ийм байж болохгүй шүү дээ!! Би тэдний алдаатай төлөвлөгөөг нь баталдаггүй! гэж хэлэв. Тэр миний үгийг сонсож байснаа:

- Хайгуулын ажлын төлөвлөгөөнд алдаа байгаа бол түүнийг батлахгүй байгаа чинь чиний зөв, харин бусад асуудлаар эхлээд чи надтай сайн зөвлөж, ярьж байх хэрэгтэй! Ер нь ЗХУ-аас ирж байгаа мэргэжилтнүүдийн асуудал бол Засгийн газар хоорондын хэлэлцээрээр зохицуулагдаж байдаг асуудал шүү дээ. Жил бүр “Монгол-Зөвлөлтийн эдийн засгийн хамтын

ажиллагааны засгийн газар хоорондын комисс” хуралдаж байна. Тэнд чиний яриад байгаа энэ асуудлыг тавиад шийдүүлж болно. Чи Зөвлөлтөөс ирсэн мэргэжилтнүүдийг ил шүүмжлэж, мэдэхгүй, чадахгүйгээр нь дуудаж, болохгүй! хэмээн зөвлөх, аргадах зэрэгцүүлэн хэлж байсан юм.

Гэхдээ би маргааныг зөвхөн ЗХУ-аас ирсэн мэргэжилтнүүдтэй хийдэг байгаагүй юм аа. Та нар “Эрдэнэт уулын баяжуулах үйлдвэр”-ийн тухай уншсан, сонссон байх.

5. “Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр”

Зэс, молибденийн арвин их баялагтай, энэ орд газрыг нутгийн ардууд “Эрдэнэтийн овоо” гэж нэрлэдэг байж. Нэрнээс нь хархад л энэ газар “эрдэнэ” байна гэдгийг хүмүүс эртнээс мэдэж байсан байж болох юм. Энд зэсийн том орд байгааг анх Чехословак улсын геологчид судлаж тогтоосон юм шүү дээ. Энэ ажил эхэлсэн түүх та нарт сонин байж болох юм. 1960-аад оны эхээр Чехословак улсын геологчид монголд ирж, манай геологчидтой цаашид хамтран ажиллах төлөвлөгөө хэлэлцсэн юм. Тэд нар Хөвсгөл аймгийн геологийн газрын зургийг манайхтай хамтарч хийх санал тавьсан юм. Хөвсгөл аймаг бол үзэсгэлэнтэй, сайхан байгальтай нутаг юм шүү дээ. Тийм учир түүнийг “Монголын Швейцари” гэж манайхан нэрлэдэг юм. Та нар боломж олдвол Хөвсгөл аймгийн Баянзүрх, Улаан уул, Цагаан нуур сумдын нутагт очиж үзээрэй!

КЮ: Бид нар тэр нутгаар явж байсан шүү!! Би чинь монгол орноор багагүй явсан хүн шүү! Миний очоогүй аймаг бараг байхгүй! Монгол орон физик газар зүйн хувьд ч судлаачдын сонирхолыг эртнээс нааш сорзон адил татдаг байж. Маш сонирхолтой. Энд мөнх цастай өндөр сүрлэг уулс, өргөн гол мөрөн, нүд алдам уудам тал, говь, цөл нутаг аль аль байна! Түүнээс гадна ургамал, амьтан, цаг агаарын хувьд ч их сонирхолтой! Харамсалтай нь Япон хүмүүс монгол орныг сайн мэдэхгүй байна.

ЧХ: Аа, Тийм үү! “Япон хүмүүс монгол орныг сайн мэдэхгүй!!” гэж та хэлээ. Би тантай санал нэг байна. Энгийн Япон хүмүүс монгол орныг зөвхөн уудам тал нутгаар л төсөөлөн боддог юм шиг байгаа юм. Би энэ сэдвээр Япон хүмүүстэй ярилцаж байгаагүй. Гэвч сүүлийн үед манайд Япон улсаас жуулчид олноороо ирдэг боллоо. Тэд нарын тухай зарим нэгэн мэдээ, мэдээллийг манай хэвлэл мэдээллийн хэрэгсэлүүд дамжуулж болсон байна. Японоос ирсэн ихэнх жуулчид “монголын хязгааргүй тал нутаг, нүүдэлчдийн ахуй амьдрал, ёс заншилтай танилцахаар ирсэн!” хэмээн ярьсан байдаг юм билээ. Японд монголын тал нутаг шиг уудам тал байхгүй байх л даа. Ийм өргөн уудам нутагт ийм цөөхөн хүн амьдран суудаг нь ч Япон жуулчдад сонирхолтой байж болох юм. Тийм биз? Дээр

нь бас байгалын ийм их эрдэс баялагтай болох нь ч сонин байж болох юм. Монгол орон бол геологийн тогтцийн хувьд ч Япон хүмүүсийн сонирхолыг татах ёстой хэмээн би боддог юм. Харамсалтай нь Японы геологчид монгол орны геологийн тогтоцийг судлах, геологийн зураг зохиох зэрэг асуудлыг сонирхохгүй байх шиг байна. Энэ сэдвээр Япон–Монголын судлаачид хамтран ажиллавал сонирхотой үр дүнд хүрнэ хэмээн би боддог юм.

Хөвсгөл аймаг ийм үзэсгэлэнтэй сайхан байгальтай болохоор Чехословакийн геологчид түүний геологийн зургийг хийхээр сонгож авсан байж магадгүй. Тэгээд дараа жил нь геологийн зураг зохиох Чехословакийн мэргэжилтнүүд ирлээ. Тэд нар манай мэргэжилтнүүдийн хамтаар Хөвсгөл аймаг явжээ. Хөвсгөл аймаг явахад заавал Булган аймгийн нутгийг дайрч явдаг шүү дээ. Ингээд тэдэнтэй хамт явж байсан манай нэг геологич “Эрдэнтийн овоо”-г тэдэнд зааж өгсөн байна. Ингээд Чехословакийн мэргэжилтнүүд тэндээс дээж авсан байна. Тэд нар нутагтаа буцаж очоод нөгөө дээжээ шинжлэж үзсэн байх. Тэгээд энд “зэс, молибденийн орд байж магадгүй!” гэсэн анхны таамгийг дэвшүүлсэн юм билээ. Хожим манай мэргэжилтнүүд Чехословак улсын геологчид “газрын сорви”-иор геологийн хайгуул хийх арвин их туршлагатай болохыг нь мэдсэн юм. Түүнээс хойш тун чиг удалгүй, Чехословакийн талаас манайд хандаж, “Эрдэнэтийн овоо” орчимд геологийн хайгуул судалгааг хамтарч хийх санал тавьсан юм. Манай тал энэ асуудалд маш хурдан хариу өгсөн. Ингэж “Эрдэнэтийн овоо”-нд геологийн хайгуул, судалгаа хийх Монгол–Чехословак улсын хамтын ажиллагаа эхэлсэн юм. Энэ бол 1964 онд болсон үйл явдал юм шүү дээ.

Би Чехословак улсаас ирсэн мэргэжилтнүүдтэй байнга холбоотой ажилладаг байв. Зарим үед тэдэнтэй бас ширүүн маргаан өрнүүлдэг л байлаа. Чехословак улсын геологчдийн ахлагчаар Эмануэль Коменек гэдэг хүн ажиллаж байв. Тэр бол ажлаа арван хуруу шигээ сайн мэддэг, өндөр зэрэглэлийн мэргэжлийн геологич хүн байсан юм. Тэр хүн бид хоёрын хороонд хайгуулын ажлын аргачлалын асуудлаар санал зөрөлдөж, ширүүн маргаан болсон юм. Урт нь 3,000 м өргөн нь 1,500 м талбайд өрөмдлөг хийх ёстой байв. Тэр хүн энэ талбайд 135 х 135 гэсэн харьцаатайгаар гурван цооногт өрөмдөнө гэсэн санал дэвшүүлж байв. Би түүнд “Та ингэж болохгүй. Өрөмдлөгийг ингэж хийвэл цаг их орно. Та энд 10 жил ажиллах хэрэгтэй болно шүү!!” гэж хэлдэг байв. Тэгээд би түүнд “Хоорондоо 400 м-ийн зайтай долоон шугаман дээр өрөмдлөг хийнэ. Нэг шугаман дээр хийж байгаа өрөмдлөгийн хооронд 200 м зайтай байна!!” гэсэн саналыг хэлэв. Гэтэл тэр “Би зөвшөөрөхгүй!!” гээд зөрөөд байв. Ингээд бид хоёрын энэ маргаан удаан үргэлжлэв. Тэр хүн “Би 135 х 135

харьцаатай гурван цооног өрөмдөж туршисан. Энд орд байна гэдэг нь тодорхой болсон шүү дээ. Мэдэж байгаа зүйлдээ тулгуурлаад цаашаа мэдэхгүй зүйлрүүгээ явах хэрэгтэй гэж дэлхийн алдартай геологчид сургасан байдаг юм!!” гэсэн тайлбар хэлээд надад огт бууж өгөхгүй байв.

Тэгээд би түүнд “Миний хийсэн аргачлалаар хийвэл хий, хийхгүй бол одоо ингээд ажлаа зогсоо!” гэж хэлсэн юм. Ингээд бидний маргаан гацаанд орчихоод нилээд хугацаа өнгөрөв. Тэгж байтал Чехословак улсын геологийн яамны орлогч сайд Моймир Краутер гэдэг хүн манайд ирхээр боллоо. Тэр хүн ЗХУ-ын Свердловскийн их сургууль төгссөн хүн байв. Би түүнийг өөрийнхээ ажлын өрөөнд урьж ирүүлээд ярилцлаа. Би түүнд өөрийн дэвшүүлсэн аргачлалын давуу талуудыг тайлбарлаж өглөө. Энэ ярианы явцад тэр хүн өөрөө хайгуулын ажлын туршлага байгатай хүн болох нь тодорхой болж байгаа юм. Бид хоёр яриагаа орой ажил тарсны дараа цааш үргэлжлүүлээ. Тэр “орос заншил”-аар нэг шил водка авч ирсэн байв. Бид хоёр түүнийг нь хувааж уулаа. Ингээд шөнийн 12 цаг болж байхад тэр миний өрөөнөөс гарч явав. Би ярианыхаа төгсгөлд түүнд “Өрөмдлөгийг зөвхөн миний аргачлалаар хийнэ. Өөр аргачлалыг бол би зөвшөөрөхгүй шүү!” гэж шууд хэлсэн юм. Өөрийнхээ мэргэжилтнийг хамгаалаад надтай маргаад байх нь тэр хүнд хэцүү байсан байж магадгүй. Хэсэг дуугүй сууснаа “За, би мэргэжилтэнтэйгээ энэ асуудлаар дахин ярилцаад үзье!” гэж хэлээд явсан юм. Маргааш нь тэр үнэхээр бүх асуудлыг миний саналаар шийдсэн байж билээ.

КЮ: “Эрдэнэтийн зэс, молибдений орд газар”-ыг хамтарч ашиглах, баяжуулах үйлдвэрийг барьж ашиглалтанд оруулах асуудлыг Монгол-Зөвлөлтийн засгийн газар хоорондын гэрээгээр зохицуулсан байдаг юм билээ. Чехословак улс энэ ажилд оролцохоос татгалзсан юм уу? Энэ ямар учиртай юм бэ?

ЧХ: Чехословак улс энэ ажилд оролцохоос татгалзаагүй юм аа. Гэвч энэ асуудлыг Монгол-Зөвлөлтийн засгийн газар хоорондын гэрээгээр зохицуулсан юм. Үүний учрыг одоо танд хэлж өгье! 1968 оны хавар Чехословакад болсон улс төрийн томоохон үйл явдал Чехословакийн геологчид манайд эхэлсэн ажлаа дуусгалгүй буцахад хүргэсэн юм. Тэр үед Чехословак улсад социализмыг эсэргүүцсэн ард түмний томоохон хөдөлгөөн эхэлсэн шүү дээ. “Прагийн хавар” нэрээр алдаршсан энэ үйл явдлын тухай та нар уншсан байж магадгүй. Үүнээс өмнө 1956 онд Венгерт бас яг ийм хөдөлгөөн гарч байлаа. Чехословак болон Венгериин ард түмэн тэр үед юуг хүсэж байсан бэ? Юуны өмнө тэд социалист нийгэмийг байгуулах явдлаас татгалзахыг өөрсдийн засгийн газруудаас шаардаж байсан юм. Бас тэдний улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралд ЗХУ-ын нөлөө улам бүр гүнзгийрч байгаа явдлыг эсэргүүцэж байсан юм.

Будапештед Зөвлөлтийн цэрэг орж ард түмний эсэргүүцлийн хөдөлгөөнийг дарсан юм. Харин Чехословак улсад “Варшавын гэрээний орнууд”-ын цэрэг орсон шүү дээ. Эх нутагт нь болсон ийм үйл явдлын улмаас Чехословакийн геологчид манайд эхлүүлсэн ажлаа дуусгаж чадаагүй юм. Ер нь геологи хайгуулын ажил, түүний дотор орд газрын хүдрийн нөөцийг тогтоох ажил гурван үе шаттай явагддаг юм. Чехословакийн геологчид манай геологчидтой хамтраад энэ орд газрын хүдрийн нөөцийг тогтоох эхний үе шатны ажлыг бүрэн дуусгасан юм. Харин хоёрдахь үе шатны ажлаа эхлэхээр бүх бэлтгэлээ хангагдаад байтал дээрхи үйл явдал эхэлсэн юм. Ингээд тэд нар нутаг буцсан юм. Тэгээд орд газрын хүдрийн нөөцийг тогтоох хоёр дахь шатны ажлыг манай геологчид дангаараа хийж гүйцэтгэсэн юм. Чехословакийн геологчидтой хамтраад ажлын бэлтгэлийг сайтар хийсэн туд энэ ажлыг хийж гүйцэтгэхэд манай геологчидод ямар нэгэн саад, бэрхшээл тохиолдоогүй юм. Ингээд дараа жил нь хүдрийн нөөц тогтоох гуравдахь шатны ажил эхлэх ёстой байв. Гэтэл манайханд энэ том ажлыг эхлүүлэх санхүүгийн эх үүсвэр байсангүй. Ингээд энэ байдлаас гарах арга замыг манай Засгийн газар идэвхтэй хайж эхэлсэн юм. Тэр үед олон санал гарч байсан байх. Гэвч эцсийн дүнд ЗХУ-ын засгийн газарт энэ асуудлаар хандах нь зүйтэй гэсэн шийдвэр гарсан юм. ЗХУ-ын Засгийн газар манай талын саналд маш хурдан, маш нааштай хариу ирүүлсэн юм. Үүнд бид нар эхлээд маш их гайхаж байж билээ. Учир нь тэр үед ЗХУ-д тавьсан ямар нэгэн асуудал шийдэгдэхэд маш их цаг хугацаа ордог, олон сар, магадгүй олон жил хүлээлгэдэг, ихэнх тохиолдолд татгалзсан хариу өгдөг байв. Энэ удаа тийм явдал болсонгүй. Энд ихээхэн том учир, шалтгаан байсныг бид нар хожим ойлгосон юм.

Та нар 1970 онд Чили улсад төрийн эргэлт гарсан тухай уншсан байж магадгүй. Тэр үед генерал Августино Пеночитийн тушаалаар ерөнхийлөгчийн ордонг бөмбөгдөж, Сальвадор Альендегийн тэргүүлсэн Чилийн “Ардын нэгдлийн засгийн газар”-ыг түлхэн унагасан юм. Ингээд Августино Пеночит тэргүүтэй цэргийн хунт засгийн эрхэнд гарч ирсэн юм. Энэ үйл явдлаас өмнө ЗХУ, Сальвадор Алендегийн тэргүүлсэн “Ардын нэгдлийн засгийн газар”-тай зэсийн баяжмал нийлүүлэх их том гэрээ хийгээд байж. Тэгээд Чилээс авсан зэсийн баяжмалаа боловсруулах олон тооны үйлдвэрийг өөртөө байгуулаад байж л дээ. Гэтэл Чилид төрийн эргэлт гарснаар энэ төлөвлөгөө нуран унасан юм байж. Яг ийм эгзэгтэй үед нь манай засгийн газар “Эрдэнэтийн зэс, молибдений орд газар”-г геологийн хамтарсан судалгаа хийж, хүдрийн нөөцийг тогтоох санал тавьсан юм байж л дээ. Ийм учир шалтгааны улмаас манай санал маш хурдан шийдэгдсэн юм билээ. 1971 оны 11-р сард ЗХУ-ын геологи хайгуулын маш том анги манайд орж ирсэн юм. Тэд нар шууд л ажилдаа

ороод ердөө нэг жилийн дотор энэ орд газрын зэс, молибдений хүдрийн нөөц тогтоох бүх ажлыг бүрэн дуусгаж байлаа. Ингэж ЗХУ-тай хамтарч эхлүүлсэн ажил ийм хурдтай, ийм өндөр үр дүнтэй дуусаж байхыг бид нар анх удаа үзэж билээ.

ИЛ: “Эрдэнэтий зэс, молибденийн орд газар”-ын хүдрийн нөөцийн хэмжээг анх хэдэн тонн гэж тогтосон юм бэ?

ЧХ: 1972 онд анх энэ орд газрын баталгаатай хүдрийн нөөцийн хэмжээг 546 сая тонн, металлыг нь 4,3 сая тонн хэмээн тогтоосон юм. “Орд газрын хүдрийн нөөц” гээд байгаа чинь бол чулуу, шороотой холилдсон хэсгийг хэлж байгаа юм. “Металл” гэдэг нь бол тэр хүдрээс гаргаж авах боломжтой зэс, молибден болон бусад дагалдах элементүүдээ хэлж байгаа юм. Эхний хайгуул судалгааг орд газрынхаа хөрсний өнгөн хэсэг дээр нь хийсэн юм. Хожим гүн рүүгээ орсон судалгааг хийсэн. Энэ судалгаагаар энэ орд газрын хүдрийн нөөц нь гурав дахин, металл нь хоёр дахин нэмэгдсэн юм. Одоо газрын гүн рүүрээ орох тусам хүдрийн агууламж нь багасаад, баяжмал үйлдвэрлэх зардал өндөрсөж байгаа. Гэхдээ л манай геологчдийн тооцоогоор дахиад гуч гаруй жил ажиллах хүдрийн нөөц бий. Эдүгээ энэ үйлдвэр жилд 25 сая тонн хүдэр олдворлож, 500 мянган тонн зэсийн баяжмалыг үйлвэрлэн гаргаж байна. “Эрдэнэт уулын баяжуулах үйлдвэр”-т нийтдээ 6000 хүн ажилладаг. Энэ үйлдвэрийг дагаад 90 гаруй мянган хүн оршин суудаг Эрдэнэт хот бослоо шүү дээ. Энэ чинь манай улсын гуравдахь том хот болоод байгаа юм. “Эрдэнэт уулын баяжуулах үйлдвэр” ашиглалтанд орсноосоо хойш гуч гаруй жил ажиллаад байна.

Анх хүдрийн нөөцийг тогтоох ажлыг амжилттай дууссаны дараа энэ орд газрыг ашиглах болон “Эрдэнэт уулын баяжуулах үйлдвэр” байгуулах тухай асуудлаар Монгол-Зөвлөтийн засгийн газар хооронд гэрээ байгуулагдсан юм. Харин энэ гэрээ манай талд тийм ч ашигтай, сайн гэрээ болж чадаагүй юм аа. Ер нь энэ орд газрын хүдрийн нөөцийг тогтоох болон түүнийг ашиглах асуудал яригдаж эхлэх үеэс эхлээд энэ асуудлыг тойрсон маш том улс, төр үзэл суртлын ажил явагдаж эхэлсэн юм. Тухайбал, орд газрын хүдрийн нөөц ашиглах болон зэс молибденийн баяжмалыг гадаадын зах зээл дээр зарах зэрэг асуудлаар манай талаас гарсан аливаа саналыг хүлээж авахаас шууд татгалздаг байв. Мөн эдгээр асуудлаар ямар нэгэн байдлаар шүүмжлэл хэлбэл “Монгол-Зөвлөтийн найрамдалт харилцаанд сэв суулгах оролдлого хийлээ!!!” гэж тодорхойлдог байв. Энэ байдал нь гэрээг манай талд ашигтайгаар байгуулах боломж олгоогүй байж болох юм. “Эрдэнэт уулын баяжуулах үйлвэр” ашиглалтанд орсон эхний жилүүдэд манай тал түүнээс ямар ч ашиг авч байгаагүй юм шүү дээ. Харин улсын төвлөрсөн төсвөөс түүнд дотаци төлдөг байлаа.

Тэгээд 1980-аад оны эхээр манай хэсэг эдийн засагчид МАХН-ын ТХ-ны ерөнхий нарийн бичгийн дарга Ю. Цэдэнбал гуайд хандаж, энэ байдлыг засаж, залруулах арга хэмжээг яаралтай авах санал тавьж байсан юм. Тэдний тоонд Улсын төлөвлөгөөний комиссын өндөр албан тушаалтнууд, зарим яамдын сайд нар багтаж байсан юм билээ. Гэтэл тэд нар энэ асуудлаар Ю. Цэдэнбал гуайн дэмжлэгийг авч чадаагүй юм. Үйл явдал эсэргээрээ эргэж, удалгүй энэ асуудлыг анх гаргаж тавьсан эдийн засагчдийг ажлаас нь халах асуудал яригдаж эхэлсэн байдаг юм. Энэ асуудал яригдаж эхлээд удаагүй байтал 1984 онд манай оронд улс, төрийн нэг том үйл явдал болсон юм. 1984 оны 8-р сард МАХН-ын Төв Хорооны 8-р бүгд хурал хуралдаж энэ намыг он удаан жил удирдсан, ерөнхий нарийн бичгийн дарга Ю. Цэдэнбалыг учир битүүлэг шалтгаанаар бүх албан тушаалаас нь огцруулсан юм. Тэр үед чухам юу болсон талаар Г. Надиров гуай “Ю. Цэдэнбал. 1984 он” гэдэг номондоо маш тодорхой бичсэн байна билээ. Та нар тэр номыг олж уншиж үзээрэй. Г. Надиров гуай энэ хоёр үйл явдал цаагуураа ямар холбоотой байсныг маш тодорхой тайлбарлаж бичсэн байна билээ. Энэ үйл явдал болж өнгөрсөнөөс хойш ч манай тал энэ гэрээг засаж, сайжруулах талаар ОХУ-ын засгийн газарт олон удаа хандаж байсан юм. Тэгээд энэ асуудлыг 1990-ээд онд ЗХУ болон бүх социалист системийн орнуудад өрнөсөн ардчилал, шинэчлэлийн үйл явцын нөлөөн дор сая шийдэгдэх боломтой болсон юм. Одоогоор гэрээг 5 дахь удаагаа засварлаад байна. Цаашид ч бас сайжруулах асуудлууд нийлээд бий. Олон нийтэд ил болоогүй олон асуудлуудын дотор зэс, молибденийн баяжмал нийлүүлэх гэрээ багтаж байгаа юм. Энэ гэрээний заалтуудыг үйлдвэрийн гүйцэтгэх захирлаас өөр хүн мэддэгүй юм. Хоёр тал ингэж тохирсон юм. 2000 оноос эхлээд энэ үйлдвэр манай улсад татвар төлж эхэлсэн.

Одоогоор манай засгийн газар энэ орд газрын хүдрийн нөөцийн 51 хувийг, ОХУ-ын Засгийн газар 49 хувийг нь ашиглаж байна. Орд газрын нөөцийн 51 хувийг ашиглах эрх монголын талд байдаг тул “Эрдэнэт уулын баяжуулах үйлдвэр”-ийн гүйцэтгэх захиралаар монголын талын санал болгосон хүнийг томилдог болсон. 1990-ээд оноос хойш энэ үйлдвэрийн гүйцэтгэх захиралын албан тушаалд монгол хүн томилогдсоор ирлээ. Гэхдээ энд бас нэг дутагдал шинээр буй болоод байгаа. Юу гэвэл, манай парламентийн сонгуульд ялалт байгуулж, засгийн эрх авсан улс төрийн нам өөрийн хүнийг энэ том үйлдвэрийн гүйцэтгэх захиралаар томилох сонирхолтой болсон юм. МАХН засгийн эрх авбал өөрийн хүнийг гүйцэтгэх захиралаар нь томилдог, АН засгийн эрх авбал түүнийг нь өөрчлөөд өөрийн хүнийг гүйцэтгэх захиралаар нь томилдог болсон. Энэ бол тийм ч их сайн зүйл биш. Бас одооноос эхлээд сайтар бодож

төлөвлөх нэг чухал ажил бий. Гуч орчим жилийн дараа зэс, молединийн нөөц дуусаад, “Эрдэнэт уулын баяжуулах үйлдвэр” хаагдана. Үүний дараа Эрдэнэт хотод оршин суугчдийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал босож ирнэ. Энэ бол тийм ч амар хялбар шийдэх асуудал биш л дээ. Тийм учраас одооноос энэ асуудалд анхаарлаа хандуулж, тухайн үед босож ирэх асуудлыг шийдэх арга замыг бодож олох ёстой юм.

6. Монголчууд эрдэс баялагийг ашиглаж байсан түүхээс

ИЛ: Монголчууд байгалын эрдэс баялагийг ашиглаж ирсэн урт удаан хугацааны түүх байдаг байх. Харин монгол орны геологийн тогтоцийг хэдий үеэс судлаж эхэлсэн юм бэ?

ЧХ: Жилийн дөрвөн улиралаар бэлчээр сэлгэн нүүдэл хийж амьдардаг нүүдэлчин удамт монголчууд байгалын эрдэс баялагаа ашиглаж ирсэн урт удаан хугацааны түүх бий. Үүнийг манай археологчдийн хийсэн судалгаанаас харж болно. Монголын Үндэсний музей болон Занабазарын нэрэмжит Монголын дүрслэх урлагийн музейд тавигдсан үзмэрүүдийг та нар үзсэн байх. Тэнд монгол нутгаас олдсон чулуун зэвсэг, хүрэл, төмөр зэвсгийн үеийн маш сонирхолтой үзмэрүүд тавигдсан байдаг шүү дээ. Монгол нутагт амьдарч байсан эртний хүмүүс чулуу, хүрэл, төмөрийг олдворлож боловсруулаад, өөрсдийн ахуйн хэрэгцээний болон гоёл, чимэглэлийн зүйлүүдийг хийдэг байж. Хүрэл, төмөрийг олдворлох боловсруулах арга, технологи нь маш өндөр түвшинд хүрсэн байсныг эдгээр олдворууд гэрчилж байгаа юм. Тэдний алт, мөнгөөр хийсэн гоёл, чимэглэлийн зүйлс өөрийн хэлбэр хийцээрээр хүмүүсийн анхаарлыг гойд их татдаг шүү дээ. Ер нь эртний нүүдэлчид дэлхийн соёлын түүхэнд онцгой байр, суурийг эзлэх өвөрмөгц соёлыг бүтээж чадсан гэсэн дүгнэлтийг судлаачид хийдэг шүү дээ.

Монгол нутагт өөрийн төр улсыг байгуулж явсан нүүдэлчин удамтай Хүннү, Сяньби, Тоба, Жужан, Түрэг, Уйгар, Киргизүүдийн дунд “төмөрчин” гэсэн мэргэжилтэй хүмүүс байсан тухай мэдээ түүхийн сурвалж бичгүүдэд байдаг юм билээ. Энэ тухай манай ахмад археологич Д. Навааны бүтээлүүдээс уншиж болно. Манай тооллын 552 оны өвөл Алтайн түргүүд их бослого дэгдээж, Жужан улсыг мөхөөсөн түүх байдаг шүү дээ. Энэ бослогыг манай түүхчид “төмөрчний бослого” гэж нэрлэсэн байдаг юм билээ. Бас манай тооллын 911 оны үеэс эхлээд Киданчууд төмөрлөгийн үйлдвэрлэлийн олон албадыг байгуулж байсан тухай мэдээ байдаг юм. Их монгол улс байгуулагдсан үеэс эхлээд байгалын эрдэс, баялагийг авч ашиглах асуудал төрийн бодлогоор зохицуулагдаж эхэлсэн хэмээн үзэх үндэс бий. Монголчуудын тахиж, шүтдэг уул, гол мөрөн болон бусад газарт дураараа газар ухах, элдэв үнэт чулуу, алт, мөнгө

зэргийг эрж, хайх, түүнийг олдворлох явдалд хатуу хориг тавьсан юм. Энэ тухай Чингис хааны “Их засаг хууль”-иас уншиж болно. Очсон газар бүртээ нарийн чанд мөрдөхийг шаардаж, эзлэгдсэн орнуудын улс төр, нийгмийн амьдралыг зохицуулж байсан Чингис хааны “Их засаг хууль” бол монголчуудын байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах үзэл санаа нэвт шингэсэн хууль юм шүү дээ. Тэр үед ийм хуультай орон байгаагүй байх аа. Их монгол улсын үед монголчуудын байгалын эрдэс баялгийг хайж олох, боловсруулах технологи хөгжлийнхөө дээд түвшинд хүрсэн хэмээн хэлэх үндэс бий. Том хэмжээний дайн хийхэд зэвсэг хийх өөрийн эрдэс баялагийн нөөц, түүнийг олдворлож боловсруулах технологигүйгээр ямар ч амжилтанд хүрэхгүй нь ойлгомжтой. Тэр үед ч тийм л байсан одоо ч тийм л байна. Хэдийгээр цаг, хугацааны хувьд өөр боловч үүний тод жишээг Япон улс дэлхийн хоёрдугаар дайнд оролцсон түүхээс харж болно. Тэр үед Япон улсын цэргийн зэвсэг үйлдвэрлэх технологи нь тийм ч муу биш байсан хэмээн хэлэх үндэс бий. Гэвч өөрийн эрдэс баялагийн нөөцгүй Япон орон удаан хугацаанд үргэлжилсэн том хэмжээний дайныг амжилттай явуулж чадаагүй шүү дээ. Япон улс энэ дайнд ялагдсан олон шалтгаануудын нэг нь энэ юм.

Гэтэл монголын түүхийг судалдаг зарим гадаадын эрдэмтэд тэр үед монголчууд зэр зэвсэг хийх эрдэс баялагийг өөрсдөө олдворлодоггүй, зэр зэвсгээ өөрсдөө хийдэггүй байсан мэтээр бичсэн байхыг би уншиж л байлаа. Би түүхч биш, гэхдээ ийм үзэл баримтлалыг баримталдаг хүмүүстэй би санал нийлэхгүй. Энэ бол монголын тухай ямар ч ойлголтгүй хүмүүсийн бичиж байгаа зүйл. Тэр үед монголчууд цэргийн зэр зэвсэг үйлдвэрлэх өөрийн технологитой, өөрсдөө бүх зэр зэвсгээ үйлдвэрлэж байсан. Тэр үед монголчууд монголоос өөр хаан ч байхгүй найрлагатай “болд төмөр”-ийг гарган авч түүгээрээ сэлэм хийдэг байж. Энэ бол маш хатуу боловч хөнгөн, уян хатан чанартай төмөр байж. Тийм учир монгол сэлэм амархан хугардаггүй боловч бас амархан ир нь мохдоггүй, зэвэрдэггүй зэрэг олон сайн чанартай байж. Монгол нутгаас олдсон археологийн олдворуудад хийсэн химийн анализ болон бусад судалгаанууд үүнийг хөдлөшгүй батлаж байгаа. Зөвхөн морь унасан цөөхөн монголчууд газар сайгүй давхилдаад байсан юм биш. Дайн хийхэд зэвсэг сайн байхаас гадна дайтах урлаг сайтай байх хэрэгтэй юм аа. Төмрийн хүдэр олдворлож, өндөр технологээр боловсруулаад, сайн зэвсэг хийж чаддаг энэ уламжлал тасраагүй, маш удаан үргэлжилсэн юм.

1727-1728 онд Монголд явсан жуулчин /Гимковский У. Ф./ замын тэмдэглэлдээ “Ерөө голын орчмоос олдворлодог төмрийн хүдрийг хайлуулан ширмэн тогоо, сав суулга цутгаад Хиагтад худалддаг” гэж бичиж байв. Хожим монголд орж ирсэн гадаадын компаниуд Ерөө голын

савд байдаг төмрийн хүдрийн энэ ордыг концессийн гэрээгээр ашиглах саналыг манай засгийн газарт тавьж байсан тухай архивын баримт байдаг юм. XVIII зуунаас эхлээд Англи, Швед, Орос, Америкийн жуулчин-судлаачид монгол оронд ирэх болсон байна. Энэ үеэс эхлээд Монгол орны геологийн тогтоц, эрдэс баялагийн тухай мэдээ дэлхийн олон орны анхааралд өртөж эхэлсэн байдаг юм. XX зууны эхэн гэхэд Европ, Америкийн жуулчин-судлаачдын 200 гаруй экспедици Монголд ирж ажилласан байдаг юм. Энэ экспедицүүд юуны өмнө монгол орны геологийн тогтоц, эрдэс баялагийн тухай мэдээ, баримтуудыг цуглуулж, энэ сэдвээр судалгааны ажил хийж байв. 1864 оноос Бээжин-Хаалган-Өргөө-Хиагт-Сибирийн чиглэлд ажилласан америкийн геологич Р. Помпелл Монголын зүүн-өмнөд хэсгийн геологийн тогтоц, эрдэс баялагийн тухай маш сонирхолтой баримт, мэдээнүүдийг цуглуулсан байдаг юм. Түүнээс хойш америкийн геологич-эрдэмтэд У. А. Уайт /АНУ 1869 он/, Ж. Милна /АНУ 1877 он/ нар монголын геологийн тогтоц, эрдэс баялагийн тухай мэдээ, баримт цуглуулж, хожим нийтлүүлсэн байдаг юм. Мөн Английн эрдэмтэн-геологич Д. Каррутерс, М. П. Прайс (1910), Австрийн эрдэмтэн-геологич Э. Зюсс (1910) Америкийн эрдэмтэн-геологич Р. Ч. Эндриус (1918-1919, 1922-1925, 1928, 1930) нар монгол нутагт ирж, судалгаа хийн монгол орны геологийн тогтоцийн сэдвээр зохиол бүтээлүүдээ тууривсан байдаг юм.

Төв Ази, түүний дотор Монгол орны геологийн тогтоц, эрдэс баялагийн сэдвээр маш сонирхолтой судалгааны ажлуудыг “Оросын газар нийгэмлэг” хийсэн байдаг юм. XIX зууны эхэн үеэс эхлээд “Оросын газар зүйн нийгэмлэг” Төв азийн судалгааны олон экспедицүүдийг томилон ажиллуулсан юм. Тэдгээрийн тоонд Оросын алдарт эрдэмтэн-жуулчин Н. М. Перживальский (1870), М. Б. Певцов (1878-1879), Г. Н. Потанин (1876-1899) нарын удирдсан экспедицүүдийг нэрлэж болно. Төв ази, түүний дотор Монгол орны геологийн тогтоц, эрдэс баялагийн тухай анхны маш тодорхой мэдээлэлийг дэлхий нийтэд өгч чадсан судалгааны ажлыг Оросын алдарт эрдэмтэн-геологич В. А. Обручевын удирдсан экспедици хийсэн байдаг юм. Энэ экспедици 1892-1894 онуудад Монгол оронд ирж геологийн талбайн судалгааг эхлүүлсэн юм. Түүнээс арай хожуу үед эрдэмтэн Д. А. Клеменц (1891), И. П. Рачковский (1903), П. К. Козлов (1907-1909), А. А. Чернов (1910), М. А. Усов (1913-1914), М. К. Коровин (1914), А. Е. Ферсман (1917) нарын удирдсан экспедицүүд монголд ирж ажилласан юм. “Оросын газар зүйн нийгэмлэг”-ээс хийсэн геологийн судалгааны ажлууд болон түүний эрдэмтэн-судлаачдын энэ сэдвээр бичиж хэвлүүлсэн бүтээлүүд нь одоо ч ач холбогдлоо алдаагүй байна.

Түүнээс хойш дэлхийн геологи, тектоникийг танин мэдэх, Хятад-

Сибирийн платформын хооронд орших атираат бүсийн геологийн орчинг судладаг геологичдийн тоо тасралтгүй өссөөр иржээ.

ИЛ: Монголын эдийн засгийн уул, уурхайн салбарт хэдий үеэс эхлээд гадаадын хөрнгө оруулалт орж ирсэн юм бэ? Энэ асуудалд монголчууд хэрхэн хандаж байсан юм бэ?

ЧХ: Гадаадын геологийн судалгааны томоохон экспедицүүд ажиллаж эхэлсэн тэр үеэс эхлээд монгол нутагт байгалын эрдэс баялгийг хайх олдворлох ажлыг хатуу хянадаг болсон юм. Ялангуяа алт, мөнгө болон эрднийн чулуу зэргийг хайх, олдворлох ажилд хяналт тавьдаг болсон юм.

Гадаадын геологийн судалгааны энэ том, том экспедицүүдийн цаад зорилго нь монгол орны эрдэс баялагийн асуудалтай нягт холбоотой байгааг тэдний үйл ажиллагаанаас манайхан олж мэдсэн байх. Тэгээд нутаг орноо хамгаалах, харийн хүмүүст өөрийн нутаг орны баялагийг найр тавин өгч болохгүй гэсэн үзэл санаа аажмаар буй болж эхэлсэн байх. Ингээд эхлээд Сэцэн хан, Түшээт хан, Сайн ноён хан, Засагт хан аймгийн захиарч нар өөрийн захиргаанд байгаа нутаг дэвсгэр дээр байгалын эрдэс баялагийг эрж хайх, олдворлох явдлыг хориглосон зарлиг, тушаалуудыг гаргаж, түүнийгээ хатуу мөрдөхийг шаардаж байсан юм.

1780-аад оны үеэс эхлээд монгол нутагт алт, мөнгө бусад эрднийн чулуу зэргийг хайх, олдворлох ажлыг хянах зорилго бүхийн тусгай харуулын алба буй болсон байдаг юм. Энэ тусгай харуулын алба “Алтны харуул” гэдэг нэрээр түүхэнд алдаршсан юм. “Алтны харуул” эхэн үедээ Сайн ноён хан аймгийн баруун урд хэсэг, Засагт хан аймгийн зүүн хойд хэсэг, Алтайн нурууны урд хэсгийг хянаж байж. Аажмаар түүний үйл ажиллагаа өргөжиж, хянах газар нутгийнх нь цар хүрээ улам тэлж, маш их өргөн уудам нутгийг хамрах болсон байдаг юм. “Алтны харуул” урт удаан хугацаны туршид оршин тогтнож, монгол нутагт, алт мөнгө болон бусад үнэт чулуу зэргийг зөвшөөрөлгүй хайх, олдворлох явдлыг хянах үүргээ маш сайн биелүүлж байсан тухай архивын баримтууд бий.

Монголын уул, уурхайн салбарт гадаадын хөрөнгө оруулалт анх 1900 оны үеэс эхлэн орж ирсэн хэмээн хэлэх үндэс бий. 1900 оны 3-р сарын 13-ны өдөр алт олдволох зорилго бүхий “Монголор” хувь нийлүүлсэн нийгэмлэг үйл ажиллагаагаа эхлүүлж байв. “Монголор”-ын удирдлага нь Санкт-Петербург хотноо байрлаж байсан бөгөөд түүний гол хувь нийлүүлэгчид нь Оросын бэлэвсэн хатан Мария Феодоровна, Бельгийн хаан Леопольд нар байсан тухай архивийн баримт байдаг юм. Мөн Оросын алтны “Золоторос” нийгэмлэг, Парис хотноо байрладаг үйлдвэр хөгжүүлэх оросын нийгэмлэг, Берлин хотоо байрладаг “Мендельсон К” нийгэмлэг, Санкт-Петербургийн олон улсын банк, Парис–Недерландын банк, Орос–Хятадын банк зэрэг газрууд тодорхой хэмжээгээр энэ ажилд

оролцож байсан юм билээ. Харин энэ нийгэмлэгийн “удирдах зөвлөл”-ийн бүрэлдэхүүний нэрсийн жагсаалт дотор Ли Хун Чжун гэдэг нэг хятад хүний нэр байдаг юм. Энэ хүн Хятад улсын нилээд дээгүүр албаны түшмэл байсан юм шиг байгаа юм. Тэрээр хөрөнгө оруулагчидад алт олдворлох зөвшөөрлийг Монголын талаас авч өгөх, Монгол нутагт алт олдворлох ажлыг эхлүүлэх зэрэг ажилд оролцож байсан юм шиг байгаа юм. Энэ зорилгоор 1900-гаад оны үед Бээжин хотод байрладаг Орос–Хятадын банкаар дамжуулан түүний нэр дээр нэг сая алтан рублийг Оросын талаас шилжүүлсэн баримт байдаг юм. Тэрээр Монголд алт олдворлох ажлыг эхлүүлэх зорилгоор өөрийн туслахаар ажиллаж байсан орос гаралтай Бельги улсын иргэн Фон Грот гэдэг хүнийг Монгол руу явуулсан байдаг юм. Фон Грот нь Ли Хун Чжуны туслахаар ажиллаж эхлэхээс өмнө Бээжинд суугаа Америкийн Элчин сайдын яаманд ажиллаж байсан юм билээ. Ажиглаад байхад энэ Фон Грот гэдэг хүн энэ бүх ажлуудын гол санаачлагч бөгөөд гол зохион байгуулагч нь байсан юм шиг санагддаг юм. Тэрээр анх монгол оронд алтны орд их байгаа тухай мэдээг Бельги болон Оросын нөлөө бүхий хүмүүст ойлгуулж чадсан байх. Фон Грот Монголд ирээд, юуны өмнө алт олдворлох зөвшөөрөл авахаас ажлаа эхэлсэн байдаг юм. Энэ ажилд түүнд Монголд суугаа Орос улсын консул С. Н. Шишмарев туслахыг оролдож байж. Гэвч тэдний энэ ажил бүтэлгүйтэж, Монголын тал тэдэнд ямарч зөвшөөрөл өгөөгүй байдаг юм. Ингээд Фон Грот Ерөө голын салаа Хүдэр, Харганат, Хүйтэн зэрэг голуудын сав газарт алт олдворлох ажлаа монголын талын ямар ч зөвшөөрөлгүйгээр эхлүүлсэн байдаг юм. Энэ үеэс эхлээд Фон Грот “Монголор нийгэмлэг”-ийн монгол дахь үйл ажиллагааг бүрэн удирдах болсон байдаг юм.

“Монголор” нийгэмлэг ийнхүү үйл ажиллагаагаа эхлээд удаагүй байтал Түшээт хан аймаг, Сэцэн хан аймгийн захирагчид зөвшөөрөлгүйгээр өөрийн нутагт алт олдворлож байгаа явдлыг эсэргүүцэж, “Монголор”-ын үйл ажиллагааг бүрэн зогсоох шаардлага тавьж эхэлсэн байдаг юм. Мөн нутгийн ардууд “уул, ус онгичиж, лус савдгийг догширууллаа!!!” хэмээн бухимдаж, олон аргаар тэмцэж эхэлсэн байдаг юм.

КЮ: Тэгээд “Монголор”-ын үйл ажиллагааг зогсоож чадсан уу?

ЧХ: Зогсоож чадаагүй юм билээ. Гэхдээ нутгийн ардуудын хийсэн энэ тэмцлийн үр дүнд “Монголор” нийгэмлэг алт олдворлох албан ёсны зөвшөөрөлийг монголын талаас авах, бас алт олдворлох асуудлаар монголын талтай албан ёсны гэрээ байгуулах тохиролцоонд хүрсэн байдаг юм. Ингээд 1908 онд “Монголор” нийгэмлэг монгол нутагт алт олдворлох тухай 20 жилийн хугацаатай гэрээг монголын талтай байгуулж чадсан байдаг юм. Мөн “Монголор” нийгэмлэг алт олдворлоод олсон ашгийнхаа

16,5 орчим хувийг нь монголын талд өгөх заалт энэ гэрээнд орсон байдаг юм. Энэ бол тухайн үедээ монголын талд их ашигтай заалт болсон юм. Хожим Богд хаант Монгол улсын засгийн газрын санаачлагаар энэ гэрээг дахин шинэчлэн байгуулсан байдаг юм. Шинэ гэрээгээр түүний үргэлжлэх хугацааг 20 жил биш, харин “1921 оны 5-сар хүртэл” гэж тогтоогоод, алт олдворлоод олсон ашгийнхаа 20 хувийг нь монголын талд өгч байх заалтыг оруулсан байдаг юм. Ингээд шинэ гэрээгээр “Монголор” нийгэмлэг алт олдворох ажилдаа цааш үргэлжлүүлэх боломжтой болсон байдаг юм. “Монголор” нийгэмлэг алт олдворлох ажилдаа дан америкийн техникийг ашиглаж байсан тухай мэдээ бий. Мөн энд дөч гаруй америкийн мэргэжилтнүүд ажилаж байж. Хэдийгээр тэнд америкийн техникийг ашиглаж байсан ч олдворлох ажлын бараг ихэнх хэсгийг гар аргаар гүйцэтгэдэг байсан юм билээ. 1915 онд манай Сангийн яамнаас “Монголор” нийгэмлэгийн үйл ажиллагаанд шалгалт хийсэн байдаг юм. Энэ шалгалтын дүнд энд нийтдээ 2,500 гаруй хүн ажиллаж, олдворлосон алтаа Германы Гамбург, Голландын Амстердам, Францын Парис хотноо хүргэж, зах зээлийн үнээр худалдаж байгааг нь тогтоосон байдаг юм. Мөн “Монголор” нийгэмлэг үйл ажиллагаагаа эхэлсэнээс хойш нийтдээ 15 тонн орчим алт олдворлож, 10 сая америк долларын ашиг олоод байгааг нь тогтоосон байдаг юм. Хэдэн онд, хэдий хэмжээний алт олдворлож байсан тухай маш тодорхой баримтууд манай архивт бий. Та нарт боломж олдвол тэр баримтуудтай танилцаарай! Энэ бол Монголын төр, засгийн зүгээс байгалын эрдэс баялагийг ашиглах асуудалд маш анхаарал тавьж, гадаадын хөрөнгө оруулагч нарт маш болгоомжтой хандаж байсныг гэрчлэх баримт болж чадах байх. Монголын үе үеийн төр, засгийн зүгээс байгалын эрдэс баялагийг эрж хайх, олдворлох асуудалд хандаж байсан хандлагад тухайн цаг, үеийн нөхцөл байдлаас шалтгаалаад нилээд ялгаа бий. Гэхдээ л энэ асуудал төрийн бодлогын төвд нь байнга байсаар ирсэн гэдэгтэй маргах хүн гарахгүй биз ээ. Богд хаант монгол улсын засгийн газар геологи, уул уурхайн салбарт маш идэвхтэй бодлого явуулж эхэлсэн байдаг юм. Юуны өмнө Монгол нутагт байгалын эрдэс баялагийг хайж олох, түүнийг олдворлон ашиглах асуудлыг нэн тэргүүний зорилт болгон тавьсан байдаг юм. Энэ ажилд гадаад, дотоодын хувийн компаниудыг татан оролцуулах нь зүйтэй гэсэн бодлогыг энэ үеэс анх удаа баримтлаж эхэлсэн байдаг юм. Гэхдээ энэ асуудлыг урсгалаар биш зохион байгуулалттайгаар явуулах нь зүйтэй хэмээн үзэж байжээ. Тэгээд геологи, уул уурхайн ажлыг зохицуулах зорилгоор 1913 онд “Алт, мөнгө зэрэг уурхайг нээх дүрэм”-ийг батлан гаргасан байдаг юм. Энэ дүрмээр эрдэс баялаг бүхий газрыг гадаад, дотоодын хувийн компаниудад түрээсийн болон концесийн гэрээгээр өгч ашиглуулж болохыг зөвшөөрсөн байдаг

юм. Мөн эрдэс, баялаг бүхий газрыг түрээсийн болон концессийн гэрээгээр авч ашиглаж байгаа гадаад, дотоодын компаниудаас монгол улсад төлөх хувь хэмжээг тухайн эрдэс баялагийн төрөл болон нөөцийн хэмжээ, олж байгаа ашиг зэргээс нь хамааралтайгаар харилцан адилгүй байдлаар тогтоож өгсөн байдаг юм. Тухайлбал алт, мөнгө, зэс олдворлож байгаа бол олж байгаа ашгийнхаа 20-30 хувийг нь монголын талд өгөхөөр заасан байв. Мөн цагаан, хар тугалга олдворлож байгаа бол 15-20 хувийг, чулуун нүүрс олдворлож байгаа бол 10-20 хувийг, төмөр олдворлож байгаа бол 5-15 хувийг, цагаан алт болон очир алмаз олдворлож байгаа бол 40-50 хувийг, усан болор зэрэг эрднийн чулуу олдволож байгаа бол 30-40 хувийг нь монголын талд өгч байх заалтууд орсон байдаг юм. Энэ дүрэмд уул, уурхайн олдворлох үйлдвэрлэл явуулах хүсэлт гаргаж байгаа хүн Монгол улсын иргэн бол Дотоод яаманд, гадаад улсын иргэн бол Гадаад харилцааны яаманд өргөдөл бичиж өгөхөөр заасан байдаг юм. Ийм өргөдийн хамтаар өөрийн иргэншил болон бусад бүрэн хэмжээний мэдээлэлийг өгөхөөс гадна уул, уурхайн олдворлох үйлдвэрлэл явуулахаар төлөвлөж байгаа газар нутаг, олдворлох эрдэс баялагийн төрөл, нөөц баялагийн талаар маш өргөн мэдээлэл өгөх ёстойг хатуу заасан байдаг юм. Энэ бүх баримт бичгүүдийг үндэслээд зөвшөөрөл олгож байхаар заасан байдаг юм. Тэгээд гурван төрлийн зөвшөөрөл олгож байхаар заасан байдаг юм. Энэ нь “Эрж, тэмтэрч үзэх тэмдэгт бичиг” (хайгуулын зөвшөөрөл –ред.), “Малтаж үзэх тэмдэгт бичиг” (нөөцийг тогтоох зөвшөөрөл –ред.), “Уурхайг нээн шийтгэх тэмдэгт бичиг” (ашиглалтын зөвшөөрөл –ред.) юм. Гэхдээ эдгээр зөвшөөрлийг олгохоос өмнө уул, уурхайн үйлдвэрлэл явуулах гэж байгаа тэр газар нь монголчуудын тахиж, шүтдэг газар мөн, бишийг урьдчилан тогтоож байх тухай заалт орсон байдаг юм. Монголчуудын тахиж шүтдэг уул, голын ойролцоо газарт зөвшөөрөл олгодохгүй байх тухай хатуу заалт энэ дүрэмд бий. Богд хаант Монгол улсын засгийн газар монгол нутагт байгаа байгалын эрдэс баялагийн талаархи мэдээлэлийг маш идэвхтэй цуглуулж, тэдгээрийн нөөцийг тогтоох ажлын бэлтгэлийг хийж эхэлсэн байдаг юм. Тэр үед цуглуулсан мэдээгээр чулуун нүүрс, хар төмөр, зэс, алт, мөнгө, хар, цагаан тугалга, цайр, давс, бал чулуу зэрэг эрдэс баялагийн их хэмжээний нөөц байгаа нь тодорхой болоод байж. Гэхдээ эдгээр байгалын эрдэс баялагийн нөөцийг яг тогтоож, тэдгээрийг ашиглах ажилд тодорхой шалтгаануудын улмаас ахиц гарч байсангүй. Тэр үед манай оронд гадаад, дотоодын хөрөнгө оруулалттай алт олдволдог 20 орчим уурхай, нүүрс олдворлодог 10 орчим уурхай ажиллаж байсан юм. Нүүрс олдворлодог уурхайнуудын дотор “Налайхын нүүрсний уурхай”-г нэрлэж болох юм. Хүрэн нүүрсний арвин их нөөцтэй энэ уурхайг 1915 оноос ашиглаж

эхэлсэн юм шүү дээ. Эхэн үедээ энд гол төлөв Орос мэргэжилтнүүд ажиллаж байв. Тэгээд 1922 оны 12-р сарын 22-ны өдөр манай засгийн газрын шийдвэр гарч, Налайхын нүүрсний уурхайг “улсын үйлдвэрийн газар” гэсэн статустай болгосон байдаг юм. Энэ бол 1921 оны Ардын хувьсгалын дараа байгуулагдсан Ардын засгийн газраас уул, уурхайн салбарыг хөгжүүлэх зорилгоор авч хэрэгжүүлсэн олон чухал арга хэмжээнүүдийн зөвхөн нэг нь юм. Хожим энэ өдрийг “Монгол улсын Уул уурхайн салбарын өдөр” болгон жил бүр тэмдэглэн өнгөрүүлдэг болсон юм. Өнгөрсөн жил бид нар Уул уурхайн салбарын хөгжлийн 90 жилийн ойг энэ өдөр тэмдэглэн өнгөрүүллээ.

7. Уул, уурхайн салбарт “улсын үйлдвэрийн газар”-ууд

КЮ: 1921 оны Ардын хувьсгалын дараа байгуулагдсан Ардын засгийн газар уул, уурхайн салбарт ажиллаж байсан бүх үйлдвэрүүдийг “улсын үйлдвэрийн газар” статустай болгох бодлогыг барьж эхэлсэн юм уу?

ЧХ: Тэгсэн. Тэгэхээр монголд тэр үед уул, уурхайн үйлдвэрлэл явуулж байсан аж ахуйн нэгжүүдийг “улсын үйлдвэрийн газар” гэсэн статустай болгох уу, эсвэл урьдын адил “хувийн өмчийн аж нэгж” хэвээр байлгах уу гэдэг асуудал бол өөрөө их том асуудал юм шүү дээ. Энэ бол аль ч оронд тухайн орны улс төр, эдийн засаг, нийгмийн харилцаанаас хамаарч шийдэгдэх асуудал юм аа. Монголд ч адилхан.

1921 онд Ардын хавьсгал ялснаар монгол орны улс, төр, эдийн засаг, нийгмийн харилцаа үндсээрээ өөрчлөгдөж эхэлсэн юм. Монгол орон ЗХУ-ын дараа дэлхийн хоёр дахь социалист орон болох замд орсон шүү дээ. Социалист нийгэм бол хувийн өмчийг хүлээн зөвшөөрдөггүй, хувийн өмчийг устгаад, түүний оронд шинэ социалист өмч буюу улсын өмчийг буй болгоод түүнийгээ түшэглэн оршин тогтнож байдаг нийгэм юм. Тэгэхээр Ардын хувьсгал ялсны дараа монголын уул уурхайн салбарт ажиллаж байсан хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийг “улсын үйлдвэрийн газар” гэсэн статустай болгох бодлогыг хэрэгжүүлж эхэлсэн юм. Ардын засгийн газарт уул уурхайн хөгжлийн асуудлыг эхэн үедээ Сангийн яам хариуцаж байв. Сангийн яаманд дотроо бол “Баялагийг бадруулах” нэртэй тусгай хэлтсийг шинээр байгуулаад түүнд энэ асуудлыг хариуцуулсан байдаг юм. Сангийн яам хамгийн түрүүнд “Монголор” нийгэмлэгийн өмч хөрөнгийг хурааж, түүнийг “улсын үйлдвэрийн газар” гэсэн статустай болгосон байдаг юм. Энэ асуудлаар Ардын засгийн газраас “Ухуулан тушаах бичиг” нэртэй шийдвэр гарсан байдаг юм.

1922 онд Ардын засгийн газраас “Эдийн засгийн бодлого” нэртэй баримт бичгийг боловсруулан гаргасан юм. Энэ баримт бичигт Монгол улсын засгийн газар цаашид уул, уурхайн салбарыг эрчимтэй хөгжүүлэх

бодлогыг баримтлах тухай тодорхой заасан байдаг юм. 1923 оны 8-р сарын 30-ний өдөр Ардын засгийн газраас “Уурхайн дүрэм”-ийг батлан гаргасан юм. Энэ дүрэмд уул, уурхайн салбарт зөвхөн улсын өмчинд тулгуурласан үйлдвэрийн газрууд ажиллах тухай маш тодорхой заалт бий. Энэ дүрмээр хувь хүн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд эрдэс баялагийг хайх, түүнийг олдворлох ажилд хатуу хориг тавьсан байдаг юм. Энэ дүрэм 4 бүлэг 52 зүйлийн заалт бүхий дүрэм байсан бөгөөд үүнээс хойш уул, уурхайн хөгжлийн бүх асуудлыг энэ дүрмээр зохицуулах болсон юм. Ингээд үүний өмнө хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдтэй эрдэс баялагийг ашиглах тухай байгуулсан түрээсийн болон концессийн бүх гэрээнүүдийг энэ дүрмийг үндэслээд хүчингүй болгосон юм.

1924 онд Ардын засгийн газрын шийдвэр гарч монгол орны геологийн хайгуул судалгааны ажлыг “Судар бичгийн хүрээлэн” (Шинжлэх ухааны академи –ред.) хариуцах болсон юм. 1923 онд “Судар бичгийн хүрээлэн” - гийн хүсэлтээр ЗХУ-ын Шинжлэх ухааны академийн геологийн хайгуул судалгааны экспедици Монголд ирж ажиллав. Энэ судалгааны экспедицийг гелогич-эрдэмтэн И. П. Рачковский удирдаж байсан юм. И. П. Рачковскийн удирдсан экспедици 1923-1925 онуудад Монгол орны төв хэсэг, тухайлбал Хангайн бүс болон монголын баруун талын Алтай уулын бүс нутагт судалгаа хийсэн юм. Энэ экспедицтэй бараг нэгэн үед ЗХУ-ын ШУА-ийн геологч М. Ф. Нейбург (1923 он), В. И. Крыжановский (1923-1924 он), Е. Е. Костылов, Н. М. Прокопенко (1925 он) нарын удирдсан удирдсан экспедицүүд монгол орны төвийн болон зүүн бүсийн нутагт, З. А. Лебедевын (1925 он) удирдсан экспедици баруун бүсийн Увс нуурын орчим геологийн хайгуул судалгаа хийсэн юм. 1925 онд ЗХУ-ын ШУА-ийн ерөнхийлөгч В. Л. Комаров удирдсан “Монголын комисс” нэртэй газар байгуулагдсан бөгөөд тэндээс монгол оронд ажиллаж байгаа геологийн хайгуул судалгааны бүх экспедицүүдийн үйл ажиллагааг зохицуулж байсан юм. 1929 онд “Судар бичгийн хүрээлэн” ЗХУ-ын ШУА-ийн хооронд геологийн салбарт хамтран ажиллах урт хугацааны гэрээ байгуулагдав. Энэ гэрээгээр ЗХУ-ын тал монгол нутагт гидрогеологийн хайгуул судалгааны ажлыг эхлүүлж, төв, суурин газрууд болон малын билчээрийн усны асуудлыг шийдвэрлэх зорилт тавин ажиллаж эхэлсэн юм. Аажмаар монгол орны геологийн зураглалыг зохиох ажлыг хийж эхэлсэн байдаг юм.

1928-1929 онд ЗХУ-ын ШУА-ийн геологийн хайгуул судалгааны экспедици монголын зүүн бүсийн нутагт ажилласан юм. Түүнийг геологч эрдэмтэн Н. Г. Смирновын удирдаж байв. Энэ экспедици манай Үйлдвэр, худалдааны яамны сайд С. Дангаагийн хүсэлтээр Дорнод аймгийн Баянтүмэн, Жаргалант сумдын нутагт чулуун нүүрсны хайгуул судалгааг

хийсэн байдаг юм. 1938 онд “Судар бичгийн хүрээлэн”-гийн геологийн секцийг тасаг болгон өргөжүүлсэн юм. Энэ тасгийн даргаар нь манай анхны мэргэжлийн геологч Ж. Дүгэрсүрэн гуай ажиллаж байв. Энэ хүн анх 1920-оод оны сүүлч үед Франц улсад очиж суралцсан байдаг юм. Дараа нь ЗХУ-д очиж суралцаад, геологич мэргэжитэй болоод ирсэн байдаг юм. 1939 онд “Фабрик, заводын сургууль” байгуулагдаж, 1942 онд анхны төгсөлтөө хийсэн юм. Энэ сургуулийг төгсөгчидийн олонхи нь уул, уурхайн салбарт ажиллаж эхэлсэн юм. 1940 онд Монгол–Зөвлөлтийн хувь нийлүүлсэн “Совмонголметалл” нийгэмлэг байгуулагдав.

1937 оноос ЗХУ-ын ШУА-ийн “Дорнодын геологи хайгуулын экспедици” ажлаа эхэлсэн юм. Энэ экспедици 1957 он хүртэл Монголд ажилласан юм. Энэ экспедицийн гол зорилго нь цэрэг-стратегийн ач холбогдол бүхий вольфрам, цагаан тугалга, төмөр, коксжих чулуун нүүрс зэргийн орд газрыг хайж олоход чиглэж байв. И. В. Сталин энэ экспедицийн удирдлагад “Вольфрамын орд байгааг илрүүлэх юм бол түүний том, багаас үл хамаараад шууд олдворлох ажлыг эхлүүлэх хэрэгтэй!!!” гэдэг даалгаврыг өгч байсан юм билээ. “Дорнодын геологийн экспедици” нь вольфрамын орд газрыг Чулуунхороот, Шар хад, Түмэнцогт, Чоно гол, Модот, Бүрэнцогт, Их хайрхан зэрэг газруудад илрүүлээд, хүдэр олдворлох уурхай, баяжуулах үйлдвэр байгуулсан юм. Мөн флюоритын /хайлуур жонш/ ордыг Бэрх гэдэг газарт илрүүлж, хүдэр олдворлох уурхай, байжуулах үйлдвэр ажиллуулсан байдаг юм. Бас Налайх, Зүүн булагийн чулуун нүүрсний орд, Зүүнбаянгийн газрын тосны /нефть/ ордуудыг илрүүлж, олборлох ажиллагааг эхлүүлж байсан юм. 1957 онд ЗХУ-ын Засгийн газар “Дорнодын геологийн экспедици”-ийн үйл ажиллагааг хааж, экспедицийн цуглуулсан геологийн судалгааны эх сурвалж, судалгааны материалууд болон шинжилгээний лаборатори, хэрэглэж байсан бүх техник, хэрэгсэлийг иж бүрнээр нь Монголын талд үнэ төлбөргүй шилжүүлэн өгсөн юм.

1930-аад оны сүүлч үеэс эхлээд манай улс геологийн мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх асуудалд ихээхэн анхаарал хандуулж эхэлсэн юм шүү дээ. 1960-аад оны үед манайд гадаад оронд геологийн мэргэжил эзэмшээд ирсэн хүний тоо нилээд өссөн байв. Зарим үед МУИС-ийн географийн болон хими, физикийн факультет төгссөн мэргэжилтнүүдийг геологийн чиглэлээр давтан сургалтанд хамруулж, геологи, хайгуулын салбарт ажилуулж эхэлсэн юм. Тэгээд 1950-аад оны сүүлчээр дунд сургуулийг онц дүнтэй төгссөн хүүхдүүдийг ЗХУ болон Герман, Чехословак, Унгар улсад геологийн мэргэжлээр суралцуулахаар илгээж эхэлсэн юм. Эхний ээлжинд 270 гаруй хүүхэд эдгээр орнуудад геологийн мэргэжлээр суралцахаар явсан байдаг юм. Би бол тэдний л нэг юм шүү

дээ.

1960-1990 он хүртэл Монголын геологи, уул уурхайн салбарт ажиллаж байсан хүмүүсийг “алтан үеийнхэн” гэж нэрлэдэг юм. Энэ үед Монголын эрдэмтэд- геологчид Монгол орны геологи, хайгуул судалгааны салбарт маш их ажлыг хийж гүйцэтгэсэн юм шүү. Тухайлбал геологийн цогц 14 зураг, түүний дотор бүх төрлийн ашигт малтмалын орд, тэдгээрийн байршлын зүй тогтлыг тодорхойлсон прогноз-металлогенийн зураг зэргийг нэрлэж болно. Энэ үед Монголын геологчдийн хийсэн их ажлын үр шимийг бид нар одоо л хүртэх хэмжээнд хүрээд байна.

1990-ээд оны байдлаар Монгол оронд 80 гаруй төрлийн эрдэс баялагийн (ашигт малтмалын –ред.) 1800 орчим орд буюу орд болох илрэл, хэтийн ирээдүйг нь хараахан тодорхойлоогүй 4000 гаруй эрдэс баялагийн илрэл байгааг манай эрдэмтэд-геологчид тогтоогоод байв.

Зөвхөн доод цэрдийн үеийн (Cretaceous period –ред.) нэг тэрбум тонн болон түүнээс дээш хүдрийн нөөцтэй хүрэн нүүрсний орд 20 орчим байгааг илрүүлэв. Энэ ордуудыг ил аргаар ашиглах боломжтой юм. Өмнөговь аймгийн нутагт “Тавантолгой” гэдэг газарт 6,4 тэрбум тн коксжих нүүрсний нөөцтэй орд байгааг илрүүлэв. Коксжих нүүрсний “Таван толгойн орд”-оос “Овоотын коксжих нүүрсний орд” хүртэл 200 км-ийн зайтай байдаг юм. Энэ хооронд нөөцийг нь тогтоосон 4 орд, нөөцийг нь судалж амжаагүй 8 орд бий.

8. Уул, уурхайн салбар дахь “хувийн хэвшил”. “Оюу толгой”-н асуудал

КЮ: “Оюу толгойн зэс, молибденийн орд газар”-ыг анх яаж илрүүлсэн юм бэ?

ЧХ: Зэс, молибденийн асар их нөөцтэй энэ газрыг манайхан “Оюу толгой” хэмээн эртнээс нааш нэрлэж иржээ. Манайхан байгалын нэгэн төрлийн үнэт, ховор чулууг “оюу” гэж нэрлэдэг юм. Тэгэхээр энэ нэрнээс харахад л энд эрдэс баялаг байгааг монголчууд эртнээс нааш мэдээд байсан юм шиг байгаа биз? 1930-аад оны эцсээр манайхан энд “байгалын эрдэс баялаг байна” гэсэн дүгнэлт хийсэн байдаг юм. Харин эрдэс баялагийн төрөл болон нөөцийг тогтоох асуудлыг хөндөлгүй орхисон байдаг юм. Үүнээс хойш нэг хэсэг хугацаанд энэ орчимыг “билчээрийн онцгой бүс” гэсэн нэрийн дор газрын зурагт тэмдэглэдэг байв. 1960-аад оны үеэс эхлээд энд хайгуул судалгаа хийх сонирхол манай геологчидод төрдөг байсан боловч тэр үед “Эрдэнэтийн овоо”-ны асуудал босож ирээд, бид нар бүх хүчээ түүнд төвлөрүүлээд байлаа шүү дээ. Ингээд “Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр” ашиглалтанд орсны дараа манай геологчид “Оюу толгой”-г маш их сонирхдог болсон юм. 1979 онд манай

хэсэг геологчид Оюу толгойн орчимд тандалт судалгаа-ажиглалт хийж байгаад 2-3 газарт хүдрийн овоолго байгааг тогтоож, 16 x 12 м талбайд 0,8-0,9 метрийн өндөртэй хүдэр хайлуулах зуух, 3,5 метрийн урттай хайлмаг урсах суваг, түүний дээр говь газарт ургадаг “заг” модны цагаан үнс байгааг олсон юм. “Заг” мод бол зөвхөн говь газарт ургадаг, шатахдаа маш их илч гаргадаг, шатсан үнс нь цагаан өнгөтэй байдаг зэрэг онцлогтой юм. Ингэж дээр үед хүмүүс эндээс гар аргаар хүдэр олдворлож, хайлуулж байсан нь тогтоогдсон юм. Гэвч “Оюу толгой”-д геологийн хайгуул судалгаа хийж, нөөцийг тогтоох ажлыг эхлүүлэх боломж манай геологчидод олдоогүй юм аа. Гол нь санхүү-эдийн засаг, техник-технологитой холбоотой бэрхшээлүүд нилээд байсан юм. Ер нь геологийн хайгуул судалгаа хийх нь маш их зардал шаарддаг бөгөөд тэр хэмжээгээр өндөр эрсдэлтэй ажил юм шүү дээ. 1990-ээд оны эхээр манай “Ашигт малтмалын хэрэг эрхлэх газар” энд геологийн хайгуул судалгаа хийх зөвшөөрлийг (хайгуулын лиценз –ред.) анх ВНР хэмээх компанид олгосон байдаг юм. Үүнээс өмнө хайгуул, судалгаа хийх зөвшөөрлийг монголын нэг хувийн компани аваад хэдэн жилийн дараа эргүүлж өгсөн тухай яриа байдаг юм. Энэ яриа үнэн байх. Энд геологийн хайгуул судалгаа хийх зөвшөөрөл авсан ВНР бол уул, уурхайн салбарт ажилладаг үндэстэн дамнасан (transnational corporation –ред.) дэлхийн том компаниудыг нэг юм шүү дээ. Тэд хайгуулын лиценз авснаасаа хойш ямарч ажил эхлүүлж чадаагүй юм билээ. Хайгуулын лиценз авснаасаа хойш 3 сарын дотор ажил эхлээгүй бол тэр лиценз нь хүчингүй болдог заалт манай “Ашигт малтмалын хууль”-д байдаг юм. Тэд нар ийм шалтгааны улмаас манайхаас гарч явсан байдаг юм. Гэхдээ гарч явахдаа Оюу толгойд геологийн хайгуул судалгаа хийх хайгуулын лицензээ Канад улсад бүртгэлтэй “Авенхоу майнз” гэдэг жижиг компани шилжүүлсэн юм шиг байгаа юм. Өөрөөр хэлбэл манай хуулиар хүчингүй болсон хайгуулийн лицензийг шилжүүлж өгсөн байгаа юм. Одоогоор түүнийг зарсан баримт олдоогүй байна. Энэ бол манай хуулийг яах аргагүй зөрчсөн үйлдэл юм шүү дээ. Гэтэл манай “Ашигт малтмалын хэрэг эрхлэх газар” хожим энэ хүчингүй болсон хайгуулийн лицензийг “Авенхоу майнз” компанийн нэр дээр бас шилжүүлж бүртгэсэн байдаг юм. Ингэж манайхан өөрсдөө өөрийнхээ хуулийг зөрчсөн байдаг юм. “Энэ үйл явдалд бол манай томоохон улс төрчдийн оролцоо бий!!!” гэсэн нэг яриа тасардаггүй юм. Энэ “Авенхоу майнз” компанийн захирал нь Канад улсын иргэн Роберт Фридланд гэдэг хүн байдаг юм. Энэ хүн дэлхийн уул, уурхайн ертөнцөд “хорт Боб “гэдэг муу нэрээр нийлээд нэрд гарсан хүн байв. Энэ хүн “Оюу толгой”-д геологийн хайгуул, судалгаа хийх зорилгоор “Авенхоу Майнз инк, Монголиа” гэдэг нэртэй компанийг байгуулсан байна. Гэхдээ түүнийгээ

Виржинийн арал дээр бүртгүүлсэн байдаг юм. Английн мэдэлд байдаг Виржиний арал бол татварын хөнгөлөлт үзүүлдэг офшор бүс юм шүү дээ. “Энэ компанийг байгуулахад монголын зарим улс төрчид хөрөнгө оруулсан байж магадгүй!!!” гэсэн нэг яриа бий. Тэгэхээр “Авенхоу Майнз инк, Монголиа” компани бол Канад улсад бүртгэлтэй Авенхоу Майнз компанийн охин компани болж байгаа юм шүү дээ. Ингэж “Авенхоу Майнз инк, Монголиа” компани хүчингүй болсон хайгуулийн лицензийг ашиглан Оюу толгойд геологийн хайгуул судалгааг хууль бусаар эхлүүлсэн байдаг юм.

Роберт Фридланд “Оюу толгой”-д геологийн хайгуул, судалгаа хийх ажилдаа хуучин энэ салбарт ажиллаж байсан манай геологчдийг оролцуулж эхэлсэн байдаг юм. Энэ бол түүний амжилтанд хүрэх баталгаа болсон байж болох юм. Энэ компанид ажиллаж байсан монголын геологчдийн хэсгийг геологч Д. Гарамжав толгойлж байв. Д. Гарамжав бол олон жил энэ салбарт ажилласан, ажлын арвин их туршлагатай, манай мэргэжлийн сайн геологчдийн нэг юм аа. 1990-ээд оноос хойш тэр нэг хэсэг ажилгүй байсан байх. 1990-ээд оноос манай олон сайн геологч ажилгүй болсон юм шүү дээ. Тэр үед 5,000 гаруй мэргэжлийн геологчтой, маш өндөр үр бүтээлтэй ажиллаж байсан “Монголын геологийн алба” гэдэг байгууллагыг тараасан юм. Түүнээс хойш манайх геологийн хайгуул судалгааны ажлыг бараг хийсэнгүй өдий хүрлээ. Энэ бол манай маш их том алдаа байв. Манай засгийн газар “Монголын геологийн алба” -ыг тараах алдаатай шийдвэр гаргахад нөлөөлсөн олон хүчин зүйлүүд бий. “Энэ бол гадаадын хөрөнгө оруулагчид тэдний гар хөл болсон манай дотоодын улс төр, эдийн засгийг бүлэглэлтэй нийлж хийсэн ажил мөн !!!” гэж хэлэх бүрэн үндэслэл бий.

Д. Гарамжавын толгойлсон монгол геологчид энд хэдэн жил ажиллахдаа нийтдээ 150 орчим цооног өрөмдсөн байдаг юм. Ийм олон газарт цооног өрөмдөөд үр дүнд хүрээгүй боловч өрөмдлөгийг зогсоолгүй, үргэлжлүүлсээр байж. Учир нь манай геологчид энд “юм” байгаа гэдэгт бат итгэж байсан байх л даа. Ингээд 600 м орчмын гүнээс маш их баян агууламжтай, чанарын өндөр үзүүлэлттэй зэсийн эрдэс байгааг илрүүлсэн байдаг юм. “Оюу толгой зэс, молибденийн орд газар”-ыг ингэж илрүүлсэн юм. Ингээд түүний хүдрийн нөөцийг тогтоох ажил эхэлсэн дээ.

Одоогоор “Оюу толгойн орд газар”-т 45 сая тонн зэс, 1,800 тонн алт, 6,000 тонн мөнгө (зэс нь 72 тэрбум унци, алт нь 30 сая унци) байгааг тогтоогоод байгаа юм. Энэ бол Япон улсын зэсийн хэрэгцээг 40 жил хангаж чадна гэсэн үг юм шүү дээ. Гэхдээ энэ бол түүний зэс болон бусад металлын нөөцийн бүрэн хэмжээ биш. Цаашид түүний нөөцийн хэмжээг бүрэн тогтоох нарийвчилсан судалгаа хийгдэнэ, тэр үед нөөцийн

хэмжээ дахин нэмэгдэх нь мэдээжийн хэрэг. “Оюу толгой зэс, молибденийн орд газар” одоо мэдэгдээд байгаа нөөцийнхөө хэмжээгээр Чили улсад байдаг Кодэлко зэрэг дэлхийн хамгийн том ордуудтай л өрсөлдөх хэмжээний орд болоод байгаа шүү дээ. Түүний нөөцийн хэмжээг бүрэн тогтоох үед магадгүй, тэднээс ч давж гарах боломж байж болох юм.

ИЛ: 2009 онд Оюу толгой зэс, молибденийн орд газрыг ашиглах “Хөрөнгө оруулалтын гэрээ”-г манай засгийн газар Австали улсад бүртгэлтэй Рио Тинто групп (Rio Tinto group), Канад улсад бүртгэлтэй “Авенхоу Майнз” (Ivenhoe Mines) гэдэг гадаадын хоёр хөрөнгө оруулагчтай байгуулсан байдаг. Авсрала улсад бүртгэлтэй Рио Тинто групп ямар үүрэгтэй оролцсон юм бэ?

ЧХ: Рио Тинто групп нь Роберт Фридландын удирддаг Канад улсад бүртгэлтэй “Авенхоу Майнз” компанийн хувьцааг худалдаж аваад, энэ орд газрыг ашиглах гол хөрөнгө оруулагч болсон юм. Гэхдээ Рио Тинто групп “Авенхоу Майнз” компанийн хувьцааны хэдэн хувийг авсан нь одоогоор бидэнд тодорхой биш байна. Хяналтын багц буюу 51 хувийг нь худалдаж авсан гэсэн нэг яриа бий. Канад улсад бүртгэлтэй энэ “Авенхоу Майнз” компани бол Оюу толгой шиг том ордод хөрөнгө оруулалт хийх санхүүгийн чадвартай компани биш. Уул уурхайн салбарт ийм компани олон байдаг юм шүү дээ. “Авенхоу Майнз” компани хувьцаагаа Рио Тинто компанид зарсны дараа Роберт Фридланд “Туркауз Хилл Ресурс” (Turquoise Hill Resources) нэртэй өөр нэг компани байгуулсан байна билээ. Тэрээр энэ компаниа Недерланд улсад бүртгүүлжээ. Түүний офис нь тэнд байна. Бас “OyuTolgoi Netherlands BV” гэдэг нэртэй бас өөр нэг компанийг Недерландад байгуулсан юм билээ. Энэ хоёр компанийг “Оюу толгойн орд газар” -ын ашиглалтаас орж ирэх ногдол ашгийг авах зорилгоор байгуулсан байж магадгүй. Роберт Фридланд ийм замаар татвараас зайлс хийхийг санаархаж байж болох юм. Рио Тинто групп Оюу толгойн орд газрыг ашиглах ажлыг гүйцэтгэх зорилгоор “Оюу Толгой ХХК”-ийг байгуулсан юм. Энэ компани бол монгол улсад бүртгэлтэй компани юм. Түүнийг байгуулсан гол зорилго нь Оюу толгойн орд газрыг ашиглахад шаардлагатай бүх бүтээн байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэх явдал юм. Энэ орд газарт хүдрийн олдворлолт хийх ил уурхай, далд уурхай болон олдворлосон хүдрийг боловсруулж зэсийн баяжмал гаргаж авах баяжуулах үйлдвэр баригдах юм.

Одоогоор ил уурхай болон баяжуулах үйлдвэрүүд ашиглалтанд ороод байна. Энэ баяжуулах үйлдвэр технологийн хувьд дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн, орчин үеийн эрсдэлгүй тоног төхөөрөмжөөр тоноглогдсон үйлдвэр юм. Баяжуулах үйлдвэрийн үйлдвэрлэлийн процесийн 90-95 хувь нь автоматчилагдсан бөгөөд түүнийг Delta V удирдлагын системээр

удирдахаар төлөвлөсөн юм. Удирдлагын төвд нь 2-3-аас илүүгүй хүн ажиллах боломжтой. Баяжуулах үйлдвэр эхний жилүүдэд ил уурхайгаас олдворлосон хүдрийг баяжуулна. Ил уурхайн хүдрийн агууламжийн дундажийг 0,6 хувь хэмээн тогтоосон байна билээ. Ийм дундаж агууламжтай хүдрийг баяжуулаад 25 хувийн зэсийн агууламжтай баяжмал үйлдвэрлэх тооцоо хийсэн байна билээ. Өөрөөр хэлбэл 6 килограмм зэстэй нэг тонн хүдрийг баяжуулаад 250 кг зэстэй нэг тонн баяжмал үйлдвэрлэх юм. Далд уурхайгаас 2 хувийн зэсийн агууламжтай хүдэр олдворлож, 1,8 хувийн агууламжтай зэсийн баяжмал үйлдвэрлэх тооцоо хийгээд байгаа юм. Далд уурхайг 2019 онд ашиглалтанд оруулахаар ажиллаж байна.

Манай “Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр” анх ашиглалтанд орохдоо жилд 16 сая тонн хүдэр боловсруулах хүчин чадалтай байсан. Хожим түүнд өргөтгөл хийж жилд 26 сая тонн хүдэр боловсруулах хүчин чадалтай болгосон юм. Тэгвэл Оюу толгойн баяжуулах үйлдвэр хоногт 100,000 тонн, жилд 35 сая тонн хүдэр боловсруулах хүчин чадалтайгаар ашиглалтанд орж байгаа юм. Цаашид жилд 56 сая тонн хүдэр боловсруулах хүчин чадалтай болгож өргөтгөх төлөвлөгөө бий. Ил уурхай 2013 оны 6-р сард анхны бүтээгдэхүүнээ экспортонд гаргах төлөвлөгөөтөйгээр ажиллаж байна. Гэвч би үүнд маш их эргэлзэж байна. Бүтээгдэхүүнээ экспортонд гаргахаас өмнө шийдэх ёстой маш олон асуудал бий. Одоо далд уурхайг ашиглалтанд оруулах дараагийн ээлжийн бүтээн байгуулалтын ажил ид явагдаж байна.

Манай талаас энэ “Хөрөнгө оруулалтын гэрээ”-нд Сангийн яамны сайд, Эрдэс баялаг, эрчим хүчний яамны сайд, Байгал орчны яамны сайд нар гарын үсэг зурсан юм. Гэрээнд гарын үсэг зурснаас хойш манай тал “Эрдэс Оюу толгой” компани байгуулсан. Энэ бол төрийн өмчийн компани юм. Энэ компани манай засгийн газрын нэрийн өмнөөс орд газрын нөөцийг ашиглах асуудлыг хариуцах юм. Түүнээс гадна Орд газрыг ашиглах бүх үйл ажиллагаа болон хөрөнгө оруулагч талуудын харилцааг зохицуулж байх зорилгоор 9 гишүүнтэй “удирдах зөвлөл” байгуулсан юм. Энэ 9 гишүүний 6 гишүүн нь Рио Тинто группын төлөөлөл бөгөөд 3 гишүүн нь монголын талыг төлөөлж байгаа юм. “Удирдах зөвлөл”-ийн гишүүдийн тоог хөрөнгө оруулагч талуудын оруулсан хөрөнгийн хэмжээнд нь тохируулж шийдвэрлэсэн юм.

КЮ: Одоо монголын болон дэлхийн хэвлэл, мэдээлэлийн хэрэгсэлүүдээр хөрөнгө оруулагч талуудын хооронд үүсээд байгаа маргаан их “шуугиан” дэгдээгээд байна л даа. Хөрөнгө оруулагч талуудын хооронд маргаан гарах шалтгаан байгаа юм уу?

ЧХ: Маргаан гарах маш олон шалтгаан бий. Юуны өмнө энэ нь “Оюу

толгойн орд газар”-ыг ашиглахад шаардлагатай анхны хөрөнгө оруулагч хэмжээ болон нийт хөрөнгө оруулагч хэмжээ анх хөрөнгө оруулагч талуудын тохирсон хэмжээнээс олон тэрбум доллараар өссөн явдалтай холбоотой юм. Анх “хөрөнгө оруулагч гэрээ”-г байгуулж байх үед ил уурхай болон баяжуулах үйлдвэрийг ашиглалтанд оруулахад шаардлагатай анхны хөрөнгө оруулагч хэмжээг 5,1 тэрбум доллар байхаар тохирсон юм. Гэтэл одоо Рио Тинто группын өгч байгаа мэдээгээр анхны хөрөнгө оруулагч хэмжээ 7,1 тэрбум доллар болж өссөн байна. Анхны хөрөнгө оруулагч баяжуулах үйлдвэр ашиглалтанд орсноор дуусах ёстой. Далд уурхайг ашиглалтанд оруулснаар нийт хөрөнгө оруулагч хэмжээ 14, 6 тэрбум ам. доллар байхаар талууд тохирсон байв. Гэтэл одоогийн байдлаар нийт хөрөнгө оруулагч хэмжээ 24,4 тэрбум болж өсөх нь тодорхой болоод байгаа юм. Ингэж хөрөнгө оруулагч хэмжээ анх тохирсон хэмжээнээсээ өссөн явдал нь хөрөнгө оруулагч талуудын хооронд маргаан үүсэх гол шалтгаан болоод байгаа юм. Энэ маргаан одоо монголын болон дэлхийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлүүдээр “шуугиан” дэгдээгээд байгаа юм.

КЮ: Тийм үү? Таны дээрхи яриаг чагнаж байхад бүх ажил жигд сайхан явагдаж, ил уурхай болон өндөр хүчин чадалтай байжуулах үйлдвэр ашиглалтанд орсон байна шүү дээ. Ийм ил уурхай болон баяжуулах үйлдвэрийг ашиглалтанд оруулахад зардал өсөх явдал байж болохгүй юу? Яагаад анхны болон нийт хөрөнгө оруулагчийн хэмжээ анх тохирсон хэмжээнээс өссөн явдал нь хөрөнгө оруулагч талуудын хооронд маргаан дэгдэх шалтгаан болсон юм бэ?

ЧХ: Маргаан дэгдэх маш том шалтгаан бий. Хөрөнгө оруулагч талуудын хооронд үүсээд байгаа маргаан дэгдэх шалтгааныг би жаахан холоос эхлэж тайлбарламаар байна. 1992 онд Монгол орон шинэ дөрөвдэх “Үндсэн хууль”-иа хүлээж авсан юм. Энэ үед би Ардын Их хурлын депутад (одоогийн Улсын Их Хурлын гишүүн –ред.) байлаа. Шинэ Үндсэн хуулийг боловсруулж батлахад оролцсон хүн юм шүү дээ. Энэ хуулинд “газрын дээрхи болон доорхи баялаг бол бүх ард түмний өмч” гэсэн маш тодорхой заалт орсон юм. Ийм заалт манай үүний өмнөх үндсэн хуульд ч бий. Энэ нь монгол улсын газрын дээр болон доор байгаа эрдэс баялаг нь хувийн өмч байж болохгүй гэсэн санааг маш тод илэрхийлж байгаа юм шүү дээ.

Шинэ “Үндсэн хууль” батлагдан гарснаар түүний үзэл санаанд тохируулж үүний өмнө мөрдөж байсан олон хуулинд өөрчлөлт оруулж, засаж сайжруулах үйл явц эхэлсэн юм. Ингээд 1994 онд “Ашигт малтмалын хууль”-ийг батлан гаргасан юм. Энэ хуулийг боловсруулж, батлуулах “ажлын хэсэг”-т би өөрөө орж байсан. Мөн надтай хамт манай нэрт

хуульч Б. Чимэд ажиллаж байсан юм. Энэ хуулинд эрдэс баялагийн орд газруудыг түрээсийн гэрээгээр ашиглаж болох санааг анх суулгаж өгсөн юм. Ингэж байтал 1997 онд энэ хуулийг бүр мөсөн хүчингүй болгоод “Ашигт малтмалын хууль”-ийг цоо шинээр боловсруулж, батлан гарсан юм. 2006 онд түүнийг дахин засварлаж, нэмэлт өөрчлөлт оруулан батлан гаргасан юм.

Энэ хуулиар байгалын эрдэс баялагийн ордуудыг “стратегийн ач холбогдолтой орд”, “стратегийн биш орд” гэсэн хоёр төрөлд хуваасан юм. Стратегийн ач холбогдолтой орд” гэдэг төрөлд улсын төсвийн хөрөнгөөр геологийн хайгуул хийж, нөөцийг нь тогтоосон ордуудыг оруулах заалт орсон юм. Ийм орд газарт нөөцийн 51-ээс дээш хувийг улс ашиглах эрхтэй гэсэн заалт энэ хуулинд бий. Харин “стратегийн биш орд” гэдэг төрөлд геологийн хайгуул болон нөөц тогтоох ажлыг хувийн компанийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн ордуудыг оруулахаар заасан юм. Ийм ордуудын нөөцийн 34-өөс доошгүй хувийг улс ашиглах эрхтэй гэсэн заалт орсон юм.

Энэ хуулийг “гадаад, дотоодын хөрөнгө оруулагч нарт хэт их найр тавьсан, тэдний өөрсдийнх нь захиалгаар хийгдсэн, маш их алдаатай, муу хууль болсон” гэж шүүмжлэгчид манайд олон бий. “Оюу толгойн орд газар”-ыг ашиглах “хөрөнгө оруулалтын гэрээ”-г энэ хуулийг үндэслэж байгуулсан юм шүү дээ.

“Оюу Толгой”-д геологийн хайгуул хийж, орд газрын нөөц тогтоох ажлуудыг “Авенхоу Майнз инк, Монголиа” компани өөрийн хөрөнгөөр хийсэн шүү дээ. Тийм болохоор шинэ “Ашигт малтмалын хууль” - иар энэ орд газар нь “Стратегийн биш орд газар”-ын төрөлд багтаж байгаа юм. Иймд монголын тал түүний нөөцийн зөвхөн 34-өөс доошгүй хувийг нь, “Авенхоу Майнз инк, Монголиа” компани 66 хувийг ашиглах эрхтэй болж байгаа юм.

“Хөрөнгө оруулатын гэрээ” байгуулах үед 34 хувийн нөөцийг ашиглах хөрөнгө оруулатыг Монголын тал өөрөө хариуцах асуудал босож ирсэн юм. Өөрөөр хэлбэл нийт хөрөнгө оруулалтын 34 хувийг монголын тал хариуцах ёстой болж байна хэмээн ойлгож болно. Монголын талд энэ хэмжээний хөрөнгө оруулалтыг хийх боломж байхгүй. Тэгээд Рио Тинто группээс энэ хөрөнгийг зээлээр авахаар тохирсон юм. Ингэж бид манайд ноогдож байгаа нөөцийн 34 хувийг ашиглахад шаардлагатай хөрөнгө оруулатыг Рио Тинтогоос авсан зээлийн хөрөнгөөр хийсэн юм. Монголын тал Рио Тинто группээс хоёр тэрбум орчим ам доллар зээлээр авсан. Рио Тинто групп энэ хоёр тэрбум гаруй ам долларыг сар бүр 8 % хүү бодох нөхцөлтэйгээр монголын талд өгсөн юм. Ингээд манайх маш том өртэй болсон юм аа. 2012 оны 12 сарын байдлаар зээлийн хүү нь барагцаагаар

705 сая ам. доллар болоод байгаа юм.

Манайх орд газрыг ашиглахад шаардлагатай нийт хөрөнгө оруулагын 34 хувийг гаргасны хувьд (Рио Тинто группэс авсан зээлээр хийсэн – ред) түүндээ тохирсон ногдол ашиг авах ёстой шүү дээ. Гэтэл одоогийн байдлаар манайд ирэх ногдол ашгийн хэмжээ үлэмж хэмжээгээр багасах тооцоо гараад байгаа юм. Учир нь Оюу толгойн орд газрыг ашиглахад шаардлагатай анхны хөрөнгө оруулагын хэмжээ болон нийт хөрөнгө оруулагын хэмжээ анх хөрөнгө оруулагч талуудын тохирсон хэмжээнээс олон тэрбум доллараар өссөн талаар би сая ярьсан шүү дээ. Гэтэл монголын талын оруулсан хөрөнгө хэмжээ өсөөгүй. Тэгэхээр нийт хөрөнгө оруулалтанд эзлэх манай хөрөнгө оруулагын хэмжээ 34 хувь биш түүнээс үлэмж хэмжээгээр буурч байгаа биз дээ. Тэгэхээр манайд ирэх ногдол ашгийн хэмжээ бас үлэмж хэмжээгээр буурах нь тодорхой болж байгаа юм. Энэ л асуудал хөрөнгө оруулагч талуудын хооронд маргаан гарах гол шалтгаан болоод байгаа юм.

Манайд ирэх ногдол ашгийн хэмжээ ингэж үлэмж хэмжээгээр буурах нь олон муу дагавартай юм. Юуны өмнө манайх Рио Тинто группэс авсан өрөө төлж дуусах хугацаа маш олон жилээр хойшлох нь тодорхой болоод байгаа юм. Манайх Рио Тинтогоос авсан өрөө төлж дуусахаас нааш манайд ногдол ашиг өгөхгүй шүү дээ. Анх манайх Рио Тинтогоос авсан зээлээ, түүний хүүгийн хамт төлж дуусаад ногдол ашиг авах хугацааг 2019 он хэмээн тогтоосон юм. Гэтэл одоо Рио Тинтогийн хийсэн тооцоогоор манайд ногдол ашиг өгөх хугацаа 2033 он болж хойшлоод байх шиг байна. Магадгүй түүнээс ч цаашлах байх. Бид Рио Тинтогоос авсан өрөө дарж дуусалгүй, ногдол ашиг авч амжилгүй олон жилийг ардаа үдэх тооцоо гараад байгаа юм. Гэтэл энэ хооронд Рио Тинто орд газрын нөөцийн хамгийн ашигтай хэсгийг нь сорчилон ашиглаж дуусаад, хамгийн ашиггүй хэсэг нь үлдэх нөхцөл байдал үүсээд байгаа юм. Тэр үед бид энэ орд газраас ямар ч ашиг олж чадахгүй гэсэн таамаг үүсээд байгаа юм. Дээр нь манайх Рио Тинто-д өртэй хоцрох тооцоо гараад байгаа юм.

Ингээд манай засгийн газар анхны болон нийт хөрөнгө оруулагын хэмжээ анх тохирсон хэмжээнээс өссөн явдалд тайлбар хийж өгөх хүсэлтийг Рио Тинто группэд тавьсан юм. Гэтэл энэ асуудалд Рио Тинто групп маш хойрго хандсан юм. Өөрөөр хэлбэл ямарч тайлбар хийж өгсөнгүй. Тэгээд ил болон далд уурхайг ашиглалтанд оруулах менежментийн зардал болон шаардлагатай техник хэрэгсэлийг дэлхийн зах зээл дээрээс худалдаж авах зардал өссөн гэсэн ерөнхий тайлбар хэлээд сууж байгаа юм. Маш хариуцлагагүй юм болж байна шүү дээ. Ингээд манайх хөрөнгө оруулагч талуудын уулзалт зохион байгуулах санал

тавьсан юм. Одоогийн байдлаар хөрөнгө оруулагч талуудын уулзалт хоёр удаа болоод байгаа боловч маргаантай байгаа асуудлуудаар ямар нэгэн тохиролцоонд хүрч чадаагүй байна. Ер нь байдлыг ажиглаж байхад Рио Тинто групп манай талын тавьсан асуудлыг цаашид ч хүлээж авахгүй юм шиг байна.

Энэ уулзалтын явцад урд нь монголын олон нийтэд мэдээлээгүй, маш олон хууль зөрчсөн үйлдлүүд ил болов. Юуны өмнө “Авенхоу Майнз” компани Рио Тинто группэд хувьцаагаа зараад, хөрөнгө оруулагчдын бүх эрх мэдлээ түүнд шилжүүлж өгөх үед Оюу толгойн нийт талбайн 70-80 орчим хувийг нь шилжүүлээд үлдсэн 20-30 хувийг нь “Entrée Gold” гэдэг компанид шилжүүлсэн юм байна. Тэгэхээр монголын талд нийт талбайн 70-80 хувийн 34 хувь нь оногдож байна шүү дээ. Нийт талбайн 20-30 хувийг “Entrée Gold” компанийн мэдэлд шилжүүлж өгөх шийдвэрийг “Авенхоу Майнз” компанийн хүсэлтийг үндэслэж манай Эрдэс баялаг, эрчим хүчний яамны сайд гаргасан юм байна. Энэ бол хууль зөрчсөн үйлдэл яах аргагүй мөн.

Өөр нэг хууль зөрчсөн үйлдэл бол Рио Тинто группийн байгуулсан “Оюу Толгой ХХК”-ийн бүх санхүүгийн үйл ажиллагааг монголын банк санхүүгийн байгууллагуудаар дамжуулахгүй байх шийдвэрийг Рио Тинто групп гаргасан байна. Өөрөөр хэлбэл зэсийн баяжмал экспортод гараад, ямар үнээр, хаана зарагдаад, хэдий хэмжээний орлого олсон тухай мэдээлэл монголын талд ирэхгүй гэсэн үг шүү дээ. Саяхан хэвлэл дээр гарсан мэдээгээр Рио Тинто группийн байгуулсан “Оюу Толгой ХХК” компани монголоос экспортлосон зэсийн баяжмал нийлүүлэх гэрээ байгуулсан юм байна. Гэвч аль улсын ямар гэдэг байгууллагад, ямар үнэ ханшаар, хэдий хэмжээний зэсийн баяжмал нийлүүлэх тухай мэдээллийг монголын талд өгөхгүй байгаа юм байна. Энэ бол манай хуулийг зөрчиж байгаа үйлдэл юм. Түүнээс гадна монголоос экспортонд гаргах зэсийн баяжмалын агууламжийг тодорхойлох лабораторийг одоо болтол байгуулаагүй байна. Тэгэхээр монголын тал ямар хэмжээний агууламжтай зэсийн баяжмалыг экспортонд гаргаж байгаа тухай мэдээлэлгүй хоцорно гэсэн үг шүү дээ. Ийм байж хэрхэвч болохгүй. Манай засгийн газар ийм лабораторийг өөрөө байгуулах шийдвэр гаргасан байна билээ.

Өөр нэг асуудал бол монголын тал 2 хувийн роялти-г ВНР компанид төлөх болсон явдал юм. “Оюу толгой”-д анх геологийн хайгуул хийх зөвшөөрлийг (хайгуулын лиценз –ред.) ВНР компани авсан тухай би ярьсан шүү дээ. ВНР компани хүчингүй болсон хайгуулийнхаа лицензийг “Авенхоу Майнз” компанид шилжүүлэхдээ Оюу толгойн орд газар эрдэс баялаг олдворлох үед хүдрийн нөөц ашигласны 2 хувийн роялти-гийн төлбөр авах нөхцөл тавьсан юм байна. Өөрөөр хэлбэл ийм нөхцөлтэйгээр

“Авенхоу майз” компани “Оюу толгой”-н хүчингүй хайгуулын лицензийг шилжүүлж авсан юм байна. Ийм байж хэрхэвч болохгүй.

Энэ бүхнээс харахад “Оюу толгойн орд газар”-т байгаа эрдэс баялаг бүхлээрээ ВНР компани юм уу, эсвэл “Авенхоу майнз” компанийн өмч болсон юм байна. Энэ бол манай “Үндсэн хууль”-ийн үзэл санаанд нийцэхгүй. Монголын тал Оюу толгой ХХК компанийн 34 хувийн хувьцаа эзэмшигч болсон юм шиг байна. Зарим үед манайх орд газрын нөөцийн 34 хувийг ашиглах эрхтэй биш болчихсон юм шиг санагддаг юм. Энэ “34 хувь” гэдэг тоо юунд хамаатай болох нь маш тодорхойгүй болчихоод байгаа юм шүү.

ИЛ: “Хөрөнгө оруулатын гэрээ”-г байгуулах үед ордын 34 хувийг ашиглахад шаардлагатай хөрөнгө оруулалтыг монголын тал өөрөө хариуцах асуудал босож ирсэн хэмээн та ярилаа. Миний бодлоор бол ийм асуудал угаасаа босож ирэх ёсгүй, хэрвээ босож ирсэн бол Рио Тинто группээс зээл авахгүйгээр шийдэх боломж монголын талд байсан шүү дээ. Монголын тал яагаад энэ боломжийг ашиглаагүй юм бэ?

ЧХ: Энэ асуултыг зөвхөн чи биш, маш олон хүн тавьж байгаа юм. 34 хувийг ашиглахад шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдэх өөр боломж монголыни талд байсан, гэвч түүнийг ашиглаагүй. Энэ боломжийг ашиглаагүй явдал бол монголын талын гаргасан маш том алдаа. Энэ асуудлыг шийдвэрлэх боломж байсаар байтал яагаад Рио Тинто группээс өндөр хүүтэй зээл авч энэ хөрөнгө оруулалтыг хийсэн талаар манай Засгийн газар ямар ч тайлбар хийгээгүй байна!!! Оюу толгойн орд газрын эрдэс баялаг бол монголын ард түмний өмч мөн. Түүнийг хэн ч өмчлөх ёсгүй, тэр тусмаа гадаадын хөрөнгө оруулагч нарт өмчлүүлэх ёс ерөөсөө байхгүй. Энэ бол хуулиар хатуу хориотой зүйл. Хөрөнгө оруулагч талуудын хооронд түүнийг зөвхөн ашиглах л асуудал яригдах ёстой. Үүнээс өөр яриа гадаадын хөрөнгө оруулагчидтай хийх ёсгүй. Гэтэл одоо байдал эсэргээрээ эргэчихээд байна.

“Хөрөнгө оруулалтын гэрээ”-г хийснээс хойш манай Улсын их хурлын хэсэг гишүүдийн шаардлагаар Оюу толгойн ил уурхай болон баяжуулах ашиглалтанд ороод бүтээгдэхүүнээ экспортонд гаргаад олсон ашгаараа анхны хөрөнгө оруулатыг нөхөж дууссан тэр үед орд газрын нөөцийн монголын талын ашиглах хэмжээг 51 хувь болгож өсгөх Улсын Их Хурлын тогтоол гарсан юм. Өөрөөр хэлбэл энэ орд газрыг “Стратегийн ач холбогдол бүхий орд газар”-ын төрөлд оруулахаар шийдвэрлэсэн юм шүү дээ. Гэвч манай засгийн газар энэ асуудлыг одоо болтол шийдээгүй байна. Хэзээ энэ асуудлыг шийдвэрлэхийг бид хүлээж байна.

КЮ: Та маш ноцтой зүйлүүдийг ярьлаа. Таны ярьсан зарим нарийн ширийн зүйлүүдийн тухай мэдээлэл надад байхгүй. Та мэргэжлийн хүн

учраас илүү сайн мэдээлэлтэй байгаа байх аа. Таны яриаг чагнаж суугаад “яагаад ийм байдал үүсэв?” гэсэн асуулт өөрийн эрхгүй төрж байна. Ийм байдал үүссэн шалтгаан юунд байна? Монголын тал “Хөрөнгө оруулагчдын гэрээ”-г байгуулах “мэргэжлийн баг” бүрдүүлж чадаагүйтэй холбоотой юу?

ЧХ: Мэдээлэлийн хувьд бол би танаас илүү гарах зүйл байхгүй. Ерөөсөө Оюу толгойн орд газрын хүдрийн нөөцийг ашиглахтай холбоотой асуудлууд маш далд байдалд яригдаж, мөн тийм байдлаар шийдвэрлэгдэж байгаа. “Рио Тинто групп бол үйл ажиллагаагаа маш ил тод явуулдаг, хариуцлагатай групп” хэмээн ярьдаг. Одоо тийм биш гэдэг нь тов тодорхой болсон. Тэр энэ асуудал дээр маш хариуцлагагүй хандаж байгаа. Дээр миний ярьсан зүйлүүдийн ихэнхи нь саяхан болтол өөрөөр хэлбэл хөрөнгө оруулагч талуудын хооронд үүсэн маргаантай асуудлыг шийдвэрлэх зорилгоор зохион байгуулсан хоёр талын уулзалт хүртэл монголын олон нийтэд мэдээлэгдээгүй зүйлүүд юм шүү дээ. Энэ уулзалтыг зохион байгуулснаар урьд монголын олон нийтэд мэдээлээгүй байсан олон асуудал ил болоод байна. Оюу толгойн орд газрыг ашиглахтай холбоотой үүсээд байгаа энэ нөхцөл байдлыг бий болгосон олон шалтгаан бий. Юуны өмнө монголын тал “Хөрөнгө оруулагчдын гэрээ”-г байгуулах “мэргэжлийн баг” бүрдүүлж чадаагүй гэдэгтэй би санал нэг байна. Гэхдээ энэ бол ийм нөхцөл байдал үүсэх энэ олон шалтгааны зөвхөн нэг нь юм шүү дээ. Өөр шалтгаанууд бас бий. Энэ тухай би товчхон хэдэн үг хэлье!

1990-ээд оны үеэс манайд зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих үйл явц эхэлсэн шүү дээ. Энэ үйл үйл явц амар хялбар байсангүй. Манайд улс, төр эдийн засаг, нийгмийн амьдралын бүхий л давхрагыг хамарсан гүнзгий хямрал үүссэн юм. Монгол орон өнөө болтол энэ байдлаасаа бүрэн гарч чадаагүй байна. Энэ үеэс эхлээд геологи, уул, уурхайн салбарын хөгжлийн талаар баримтлах манай төрийн бодлогод эрс өөрчлөлтүүд орж эхэлсэн юм. Юуны өмнө геологи, уул уурхайн салбарт гадаад, дотоодын хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татан оруулах бодлогыг баримтлаж эхэлсэн юм. Энэ бодлого ерөнхийдээ зөв байсан боловч түүнийг хэрэгжүүлэх шатандаа манайхан маш олон алдаа гаргалаа. Нэгэн үе гадаад дотоодын хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтанд хэт их найдлага тавих хандлага бий болсон юм. Ийм хандлага буй болсон явдал нь гадаад, дотоодын хөрөнгө оруулагч нар юуны өмнө өөрсдийнхөө олох ашгийн төлөө явж байгаа гэдгийг манайхан сайтар ухамсарлаагүйтэй холбоотой байсан байж болох юм. Хөрөнгө оруулагчид, ялангуяа гадаадын хөрөнгө оруулагчид бидний өмнөөс бидний өөрсдийн хийх ёстой ажлуудыг хийгээд өгчих юм шиг андуурч байсан явдал ч байсан байж болох юм. Ийм хандлага буй болоход хэвлэл мэдээллийн хэрэгслүүд ч

тодорхой хэмжээний үүрэг гүйцэтгэсэн хэмээн би боддог юм. Хэвлэл мэдээлийн хэрэгсэл бол нийгмийн сэтгэл зүйд маш хүчтэй нөлөө үзүүлдэг зүйл шүү дээ. Гадаадын хөрөнгө оруулагчид, ялангуяа “Оюу толгой”-н хөрөнгө оруулагчдийн сэдвээр бичдэг, тэднийг магтан дуулдаг тусгай мэргэшсэн сэтгүүлчид, сурвалчлагч нар бий болсон байх. Манай зарим нэртэй улс төрчид ч гадаадын хөрөнгө оруулагчдийг байнга магтаж ярьдаг, бичдэг байв. Тэр үед болж байсан үйл явдлуудыг одоо бодоод байхад бүгд хаа нэгэн газраас маш чадамгай удирдаад байсан юм шиг санагддаг юм. Ийм байдлаар гадаадын хөрөнгө оруулагчид нийгмийн сэтгэл зүйг өөрсдөдөө ашигтайгаар эргүүлж байсан байж болох юм. Үүнээс гадна манайд гадаадын хөрөнгө оруулагч нартай нийлж эх орныхоо баялагийг тэдэнд найр тавин өгдөг улс төр, эдийн засгийн маш хүчтэй бүлэглэл бий болоод байх шиг байна. Энэ бүлэглэлийн хүчин чармайлтаар гадаадын хөрөнгө оруулагчид 1997, 2006 онуудад манай “Ашигт малтмалын хууль”-д өөрсдөдөө ашигтай өөрчлөлтүүдийг оруулж чадсан байна. 1994 оны “Ашигт малтмалын хууль”-ийг хүчингүй болгоод шинэ хууль боловсруулах, түүндээ дахин засвар оруулах ажилд ихээхэн хүчин зүтгэсэн манай 8 томоохон улс төрч бий. Тэдний 4 нь Ардчилсан намын гишүүн, 4 нь Монгол Ардын намын гишүүн юм. Би тэднийг бүгдийг нь танина. Тэднийг ийм ажил хийснийг монголын олон нийт төдийлөн сайн мэдэхгүй байх. Гадаадын хөрөнгө оруулагчидийн эрх ашигт үйлчилдэг манай улс төр эдийн засгийн энэ бүлэглэл ийм байдлаар “Ашигт малтмалын хууль”-ийг өөрчлөж чадсаны дараагаар бас олон тооны хууль зөрчсөн үйлдлүүдийг хийсэн юм. Тухайбал “Оюу толгойн орд газар”-ын эрдэс баялагийн нөөцийг тогтоогоогүй байхад “Авенхоу Майнз” компанид түүнийг ашиглах зөвшөөрөл (ашиглалтын лиценз –ред.) олгосон байдаг юм. Мөн энэ орд газрыг ашиглах Техник Эдийн засгийн Үндэслэл ТЭЗҮ –ред.) гараагүй байхад “Хөрөнгө оруулалтын гэрээ”-г байгуулах ажлыг эхлүүлсэн байдаг юм. Гадаадын хөрөнгө оруулагчид өөрсдөө ийм үйлдлүүдийг хийх боломжгүй. Үүнийг манайд буй болоод байгаа тэд нарын эрх ашигт үйлчилдэг улс төр, эдийн засгийн бүлэглэлийн дэмжлэгтэйгээр л хийх боломжтой юм. Өөр ямарч арга байхгүй.

Гадаадын хөрөнгө оруулагч нарт хэт найр тавьж, өөрийн улсын хуулийг зөрчсөн эдгээр үйлдлүүд нь эцсийн дүндээ дээр миний ярьсан нөхцөл байдал үүсэх олон шалтгаануудыг төрүүлсэн юм шүү дээ.

Гэрээг байгуулж байх үед манай “иргэний хөдөлгөөн”-үүд эдгээр хууль зөрчсөн үйлдлүүдийг маш их шүүмжлэж, түүнийг нэн даруй засаж, залруулах, гэрээг дахин хянаж, сайжруулах шаардлагыг тавьж байсан юм. Би чинь тэдний тэмцлийг бүр эхнээс нь дэмжиж, үйл ажиллагаанд оролцож ирлээ. Бид нар олон жил, олон хэлбэрээр тэмцсэн юм аа. Гэвч

аль нь ч амжилтанд хүрээгүй юм. Манай засгийн газар эдгээр шаардлагуудыг огт хүлээж аваагүй юм шүү дээ. Саяхнаас энэ “хөрөнгө оруулатын гэрээ”-нд монголын талаас гарын үсэг зурсан, энэ гэрээг ямарч тохиолдолд ямагт хамгаалсаар ирсэн манай нэг сайд Виржинийн арал дээр компани байгуулаад, тэр компанийнхаа нэр дээр Швецарын банкинд нууц данстай байсан тухай манай хэвлэлүүд шуугиж эхлээд байна. Энэ юу гэсэн үг вэ? Энэ бол маш аюултай үйл явдлын эхлэл болж байна шүү дээ. Хаанаас авсан ямар хөрөнгөөр, ямар зорилгоор энэ компанийг Виржинийн арал дээр байгуулсан бэ? гэдэг асуултанд монголын олон нийт хариу шаардаж байна! Энэ бол зөв шаардлага. Одоо манай “Авилгалтай тэмцэх газар”-аас энэ асуудлыг шалгаж эхлээд байна.

Саяхан Монгол улсын ерөнхийлөгч Оюу толгойн орд газрыг ашиглах тухай асуудлаар Улсын Их Хурлын нэгдсэн чуулган дээр нээлттэй хэлэлцүүлэг хийлээ. Ингэснээр хөрөнгө оруулагч талуудын хооронд үүсээд байгаа маргаантай асуудлуудаар монголын тал нэгдсэн байр суурьтай болж чадсан юм. Одоогийн байдлаар “Оюу толгойн хөрөнгө оруулатын гэрээ монголын талд ашиггүй болсон!!!” гэдэгтэй монголын тал санал нэгтэй болоод байна.

КЮ: За баярлалаа.

ЧХ: За, зүгээр, зүгээр.